



ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ СУМА ЧИН ХАЙ (Хөрөг нийтлэл)

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сургааль номлол сүүлийн 30-аад жилд дэлхий дахинаа түгэн дэлгэрч, сургаалийг дагагч дэлхийн янз бүрийн шашин шүтлэгтэй олон сая хүмүүн бээр ухамсрын өндөр төвшинд хүрэх бодит замналыг дагаж, улмаар ногоо болон цагаан хоолтой энэрэнгүй үзлийг баримталж, цэвэр ёс суртахууныг өөриймшүүлж байгаа билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийгээ болон үйл ажлынхаа чиглэлийг тодорхойлж хэлэхдээ:

“Би Буддын болон Католик шашинтны аль нь ч биш. Би Үнэнд харьяалагдаж, Үнэнийг л номлодог. Та үүнийг Буддын шашин, Католик шашин, Бумбын шашин гэх юмуу аль хүссэнээрээ л нэрлэ. Би бүгдийг нь дуртайяа хүлээн авна”.

“Бид цөм Үнэн Ёсыг мэднэ. Ердөө л мартчихсан юм. Тэгээд нэгэн цагт бидэнд амьдралын маань зорилго юу юм бэ, яагаад Үнэнийг эрж олох ёстой юм, яагаад бясалгал хийх хэрэгтэй юм, яагаад Эзэн Бурхан болоод Будда, Орчлон Ертөнцийн Хамгийн Дээд Хүч гэж боддог хэн нэгэнд итгэх ёстой юм гэдгийг сануулах гэж хэн нэгэн хүн заавал ирэх ёстой болдог юм” (*Үлгэр дэвтэр хэмээх Оршил ном*).

“Сургааль маань та энэ дэлхий дээр юу л хийх ёстой байна, түүнийгээ хий, хамаг зүрх сэтгэлийнхээ угаас хий. Хариуцлагатай байж, үүнийхээ зэрэгцээ өдөр бүр бясалгал хий гэдэгт

оршино. Та өөртөө болон дэлхий ертөнцөд үйлчлэхийн тулд улам их эрдэм мэдлэг, улам их билгүүн ухаан, улам их амар амарлингуйг олж авах болно. Таны дотор өөрийн тань сайн сайхан чанар оршин буйг бүү март. Бие цогцост тань Оройн Дээд Их Бурхан оршин буйг бүү март. Зүрх сэтгэлд тань Будда оршин буйг бүү март” (Улгэр дэвтэр хэмээх Оршил ном).

“Дотоод амар амарлингуйгаа олж авснаар бид бусад бүх зүйлийг олж авна. Сэтгэлийн бүрэн ханамж, тэнгэрлэг диваажин болоод газар дэлхийн хүсэл бүхэн биелэх нь бидний мөнхийн нийцэл зохирол, мөнхийн билгүүн ухаан, хамгийг чадагч хүчний дотоод ухаарахуй болох Оройн Дээд Их Бурханы орноос ирдэг юм. Энэ бүхнээ эс олвоос бид хичнээн их мөнгө хөрөнгө, эрх мэдэлтэй, нийгэмд хичнээн өндөр байр суурьтай байлаа ч гэсэн хэзээ ч сэтгэл хангалуун болж чадахгүй” хэмээжээ (Улгэр дэвтэр хэмээх Оршил ном).

Их Багш Чин Хайн сургааль номлолын агуулга болсон “Агшин зуур билиг нээгдэх” хэмээн томъёологддог оюун санааны дээд бясалгал нь хүмүүнийг дотоод хүчтэй нь барилдуулж, мөн чанарыг нь таниулж, улмаар дээд ухамсрын бүх түвшинд хүргэх явдал юм.

Их Багш бээр хүмүүний дотоодын гэрэл, аялгуунд түшиглэсэн энэхүү дээд бясалгалын мөн чанарыг тайлж айлдахдаа: “Гэрэл, аялгуу бол бидний мөн чанар юм. Бясалгалаар та өөр руугаа орно гэсэн үг. Таныг өөрөөс тань илүү юу сайхан болгож чадах билээ. Загас усандаа байхаас илүү загасыг юу сайхан болгох вэ. Та өөрөө гэрэл юм. Бүх орчлонг бүтээж буй тэрхүү чичиргээ нь та өөрөө юм. Орчлонгийн дарга, удирдлага нь та өөрөө юм” гээд “Бясалгал бол биеийг тань хооллох хамгийн сайн хоол, дээд тан, тархийг тань хөгжүүлэх хамгийн хүчтэй энерги, оюун ухааныг тань тэлэх хамгийн сайн ном юм” хэмээжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн үйл ажиллагаа нь дараах хүрээг хамран хэрэгжиж байна.

1. Хүмүүнийг дотоод амар амгаланд хүргэх: дэлхий даяар хийх өдөр дутмын болон нэгдсэн бясалгал, ногоо ба цагаан хоолонд суурилсан энэрэнгүй үзэл, цэвэр ариун ёс суртахуун (амьтны амь хороох, худал хэлэх, хулгай хийх, садар самуунд татагдах, архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх зэргийг цээрлэх сахил), хүмүүний оюун санааны хөгжлийн арга зүй (ном, сэтгүүл, DVD, CD гэх мэт), чанагуух сэтгэлгээний тэнгэрлэг бүтээл туурвил (уран зураг, яруу найраг, дуу, хувцас загвар, гоёл чимэглэлийн болон үнэт эдлэлийн загвар зохион бүтээлт гм)
2. Дэлхийн энх тайвны төлөөх стратеги: “Суприм Мастер” телевиз, цаг уурын өөрчлөлтийн тулгамдсан асуудлаарх теле бага хурлууд, гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх тусламж, ногоогоор хоол үйлдэх зоогийн газруудын олон улсын сүлжээ, үзэсгэлэн, сайн үйлсийн төлөөх Их Багшийн хүмүүнлэгийн шагналууд, цаг уурын өөрчлөлтийн асуудал болон ногоо хоолны гарын авлагууд, санхүүгийн хандив, тусламж, улс орнуудад хүрч ном тайлах дэлхийн аянууд гм.

Их Багш Чин Хайн эдгээр стратегийн хэрэгжилтийн заримыг их зөнч Нострадамусын зөгнөлийн тайллуудад танилцуулах болно.

Шинэ Эринийг Гийгүүлэгч Бурхан, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, дэлхийн оюун санааны удирдагч түүхэн энэ хүн хэн бэ?

□ Бурхан Багш бээр: “Ирээдүйн таван зууны эцэст дээдийн ном машид эвдрэн эцсийн мөхөлдөө хүрч ирэхэд ариун энэ үзлийн судрын номлолд эзэн болох агуу их бодьсад хувилгаад ирнэ. Тэд ёс суртахууны буюу шагшаавадын ариун явдлаар машид ариуссан, бясалгал төвлөрлөөр олсон гайхамшигт эрдэм үвдис төгссөн нар байна” хэмээн айлджээ (Гэви Майкл Роач “Очир огтлогч”, 2000, Э.Нямсүрэнгийн орчуулга).

Эртний Энэтхэгийн Бурханы шашны уламжлалд Ялж Төгс Нөгцсөн Бурханы (Шагжамуни) шашныг “таван таван зуун” жил оршин дэлгэрнэ хэмээх бөгөөд тэдгээрийн “төгсгөл цаг” бүр нь таван зүйл цөвийн улмаас шашин доройтно гэж үздэг байна.

Бурханы шашин 2500 жилийн дараа буурна гэвэл энэ нь Монгол орны хувьд ардын хувьсгалын үетэй таарч байна. Энэ цагаас шашны гол агуулга болсон гэгээрэл үндсэндээ орхигдоод байхад Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бээр гэгээрлийг аль нэг шашны харъяалал, өмчлөлөөс гаргаж, дэлхийн, хүн төрөлхтний үйл хэрэг болгон мандуулан бадрааж байгаа билээ.

Бурхан Багш цааш айлдсан нь: “Энэ цагийн Бурхад, Бодисадва нар нь бясалгал төвлөрлөөр олсон гайхамшигт эрдэм үгдис төгссөн нар байна” хэмээсэн нь Их Багш Чин Хайн Арьяабалын номын цогц, бясалгалтай яв цав тохирч байна.

Тэр бээр: Арьяабалын номын цогц буюу бидний бясалгал бол үхэж төрөхөөс ангижрахын төлөө, Бурхан болсны дараа хамаг амьтныг гэтэлгэхийн төлөө, бүх орчлонг адислахын төлөө юм” гэж айлдсан нь *“бясалгал төвлөрлөөр олсон гайхамшигт эрдэм үгдис төгссөн нар байна”* хэмээсэн

Бурхан Багшийн айлдвартай тохирч байна.

Мөн “Очир огтлогч” сударт Субуди бээр *“Ирээдүйд таван зууны эцэст, таван мөчлөгийн төгсгөлд дээдийн ном сарних үест эл судрын үгсийг үнэн зөвөөр ойлгох төрөлтөн гарах болов уу”* хэмээн асуухад Бурхан Багш бээр айлдсан нь: *“Субуди, бүү тэгэж ярь! Адаг тэр үед ч эл судрын үгсийг үнэн зөвөөр тайлж ойлгох бодисадва нар гарах болно. Субуди, тэдгээр бодисадва ганц Буддад өргөл хүндлэл үйлдэж, ганц Буддагаас буяны үндэс үүсгэх бус, түг түмэн Буддад өргөл хүндлэл үйлдэж, түг түмэн Буддагаас буяны үндэс үүсгэнэ. Эл судрын үгст нэгээхэн төдий ариун сүсэг үүсгэснээр тэд бүгд цаглашгүй, хэмжээлигүй их буяны чуулган хураахыг Туунчилэн ирсэн бээр будда мэлхийгээр толилж байна”* (Очир огтлогч судар, Ошо Богдын тайлбар, Агнистын гэгээ цуврал 9, 2013, хуудас 20).

Хамаг амьтныг гэтэлгэх буюу чөлөөлөхийн тухайтад гэгээрлээс өөр арга зам гэж үгүй гэж айлдаад “Авшиг авмагц Будда болно” хэмээсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаалийг Бурхан Багш болгоохдоо: *“тэдгээр бодисадва ганц Буддад өргөл хүндлэл үйлдэж, ганц Буддагаас буяны үндэс үүсгэх бус, түг түмэн Буддад өргөл хүндлэл үйлдэж, түг түмэн Буддагаас буяны үндэс үүсгэнэ. Эл судрын үгст нэгээхэн төдий ариун сүсэг үүсгэснээр тэд бүгд цаглашгүй, хэмжээлигүй их буяны чуулган хураана”* хэмээжээ.

Бурхан Багш бээр айлдсан нь: *“Сайн цагийн Будда залрах үед түүний гэгээрлийн сургаалийг дагаж Их хөлгөнийхэн төдийгүй бусад бүх амьтан гаслангаас ангижирна”* (Богд Зонхов, Бодь мөрийн зэрэг, 2006, х.236).

Энэ үйл явц эдүгээ ёсоор болж байна.

Их Багш Чин Хай айлдсан нь: “Гэрэл болон Аялгуу бол жинхэнэ Багшийн хэмжүүр юм. Танд агшин зуур Гэрэл, Аялгуу үзүүлж чадахгүй байгаа хэн нэгэн бол Жинхэнэ Багш биш. Тэнгэрт хүрэх зам Гэрэл, Аялгуугаар тоноглогдсон байдаг (2, х 105). Би бол Будда чанарыг шууд харуулах чиглэлийн багш” (Гэгээрэл ба мунхрал, Непал, 2000.5.1).

Энэхүү бясалгалын ач буянаар дэлхий даяар эдүгээ урьд өмнө байгаагүй их чөлөөлөлт болж байгаа билээ.

□ 19-р зууны физикч, гэгээнтэн, зөнч хатагтай Блаватская (1831-1891)-гийн зөгнөлд: *“Гэгээрсэн нэгэн 1950-иад онд Азид төрнө. Бид Калийн харанхуй эриний 5000 жилийг ардаа хийх гэж байна. Ингээд Гэрэлийн эрин үе эхэлнэ. Оюун санааны шинэ залуурч Барууны ертөнцөд 1975 онд очно¹”* (ишлэл: Тайлбар зүүлтийн 1) гэжээ.

Их Багш Чин Хай 1950 онд Өмнөд Вьетнамд төрж, 1972 онд Европт очиж, 1975 онд европын иргэн болжээ.

□ 11-12-р зууны францийн зөнч Жаны шүлэглэсэн зөгнөлийн номыг “Le livre des prophetes,” нэртэйгээр Editions Jean-Claude Lattes хэвлэлийн газар 1994 онд хэвлэжээ² (шилэл: Тайлбар зүүлтийн 2).

Энэ зөгнөлд Их Багш Чин Хай, түүний сургааль номлол шинэ эринийг хэрхэн залахыг ихэд дэлгэрэнгүй буулгасан байна. Тухайлбал: “2000 оны хавиас Бурханыг зөвхөн эр хүйс тодорхойлж байсан нь больж, нэгэн эмэгтэй тодрон шинэ эриний аугаа ээж болно. Мянганы дараах мянганы эх тэр бээр мянганы дараах мянганыг Гэрэлийн эринд шилжүүлнэ. Энд зөвхөн энэрэл хайр, өглөг буян, мөрөөдөл ноёрхлоо тогтоож, хүсэл бүхэн биелнэ. 2000 оны хавьд ийм зүйл тохиосноор хүн төрөлхтний билгийн мэлмий ашгүй нэг нээгдэж, оюун ухаан нь сэтгэл болон биед хоригдсон хоригдол байхаа болино”.

Гэрэлийн эрин гэдэг нь Их Багшийн авралаар хүмүүс сая саяараа билгийн мэлмий нээгдэж, өөрсдийн дотоод гэрэл гэгээг олж үзэж, дотоодын хүч буюу Бурхантайгаа холбогдож буй дэлхий болон хүн төрөлхтнийг бүхэлд нь хамарсан урьд хожид байгаагүй энэхүү аугаа үйл явц тохиох эринийг онож хэлжээ. Энэ эринийг эхлүүлэгч нь эмэгтэй хүн байхыг, энэ цагаас эхлэн зөвхөн эргэтэйчүүд Их Багш байсан үе өнгөрөхийг зөгнөжээ. Их Багшийн Гэрэл, аялгууны бясалгалын ачаар нэгэнтээ “сэтгэлд хүлэгдэж, биед хоригдсон сүнсэн биеэ” олж авч хүмүүн бээр өөрийгээ шинээр нээснээр зөвхөн энэрэл хайр, өглөг буян, мөрөөдөл ноёрхлоо тогтоож, хүсэл бүхэн биелэх боломжтой болж байгааг маш тодорхой зөгнөжээ.

Зөнч бээр бясалгалын талаар дэлгэрэнгүй зөгнөн хэлсэн байх ба тухайлбал, “Хүмүүс агуу нэгэн бие болон нэгдэж, хэн нэг нь ердөө л ямхын төдий хэсэг нь болно. Нэгэн зүрх мэт цохилж, ганц хэлээр ярилцана.”

Ганц хэл гэдэг нь Гэрэл ба Аялгууны бясалгалыг хэлжээ. Нэг ижил бясалгалаар хэдэн сая хүн бясалгасан ч нэг зүрхтэй мэт, нэг хэлтнүүд болохыг ийн зөгнөжээ.

Тэрээр цааш зөгнөхдөө: “Хүн төрөлхийтний агуу оюун санаа шинээр төрж, би чинь хэн бэ, чулуу юмуу, мод уу, хэн нэгний хуулбар уу гэдгээ ухаарч, уг мөн чанараа таньж мэдээд эртний бурхадын нүүцыг нээнэ. Нэг хаалганаас нөгөөд дамжин шинэ амьдралын сүлжээнд нэвтэрнэ. Тэд хүч чадлаа мэдэрч, хүн төрөлхтөнд зааж сургаж, хүүхдүүд диваажин болоод дэлхийг урьдынхаасаа сайн мэдэх болж, хүмүүн бээр төрөл арилжсан мэт шинэчлэгдэнэ. Мянганы дараах Мянганы эхний харанхуй өдрүүдийн хойно аз жаргалтай өдрүүд эхэлнэ. Хүн төрөлхтөн жинхэнэ хүний зам мөрийг дахин олж, эх дэлхий зөв голдрилдоо орно” гэжээ.

Цөвүүн цаг буюу Калийн эриний эхний харанхуй 5000 жил гэж зарим зөнчийн нэрлэсэн энэ үе 2000 оны хавьд дуусч Гэрэлийн эрин эхлэхийг зарим зөгнөгч Мянганы дараах мянган гэж нэрлэжээ.

Бүх зөгнөл нь биелсэн гэгддэг сэргэн мандалтын үеийн францийн алдарт зөнч, эмч Нострадамус Их Багш Чин Хайн төрөхөөс эхлээд сургааль номлол нь даян дэлхийд түгэхийг зөгнөн хэлсэн байна³ (шилэл: Тайлбар зүүлтийн 3).

Тухайлбал:

*“For eleven more times the moon will not want the sun,
Both raised and lessened in degree,
And put so low that one will sew little gold,
That after famine and plague the secret will be revealed.”*

*“Арван нэгээс илүүтэй цаг хугацааны дотор сар нарыг таалахгүй
Өөр өөрийнхээрээ мандаж шингэнэ,
Алтан үрлийг торгоох нэгнийг дорд үзнэ,
Гай гамшиг, өлсгөлөнгийн эцэст нууц нэгэнтээ танигдана.”*

(сар = Дорно, нар = Өрнө)

Арван нэгэн үеийн нэгийг нь 60 жил гэвэл энэ зөгнөлд 600 гаруй жилийн асуудал яригдаж байна. Сар нь дорнын уламжлалт гүн ухаан, Нар буюу өрнө нь орчин үеийн шинжлэх ухааныг энд хэлсэн байх бөгөөд матери анхдагч, ухамсар хоёрдогч гэсэн судлагдахуунд суурилж бодитжуулсан материаллаг зүйлийг үнэмшилтгэйд тооцдог орчин үеийн шинжлэх ухааны чанх эсрэгээр буюу анхдагч ба хоёрдогч гэж үгүй бөгөөд ухамсар ба материйн аль аль нь хоосон чанартай, ерөөс хамаг юм өөрийн уг мөн чанараар эс бүтсэн, хоосон чанартай⁴ гэж үздэг дорнын гүн ухаан хэзээ ч өрнийг хүлээн зөвшөөрч байгаагүй юм. Дээд ертөнцийн тухайд торсион орны матери нь ухамсар болохыг онолын физик эдүгээ нэгэнт зөвшөөрсөн нь дорнын гүн ухааныг хүлээн зөвшөөрсөн хэрэг юм. Энэ үед Их Багш Чин Хайн эрин залгаж, дээрх үнэн зөв сургааль номлолыг хүн төрөлхтөнд бодитой таниулж байна.

“Алтан үрлийг торгоох нэгнийг дорд үзнэ”.

“Алтан үрэл” нь дорнын гүн ухаан юм. Олон хэмжээст орчлонгийн гол хуулиуд болох Хайрын хууль, Хоосон чанар⁴ хийгээд Үйл үрийн хуульд үндэслэсэн дорнын үнэн зөв гүн ухааныг эдүгээ гурав дөрөвхөн хэмжээс дотор бядан яваа орчин үеийн шинжлэх ухаан олон жил ойшоохгүйг энд зөгнөжээ. Буддизм нь 170-аас дээш хэмжээсийг мэддэг, тэдгээрт хүрэх аргыг ч бас мэддэг, Бурхан хийгээд түмэн бодистой хэт авианы түвшинд харьцах аргыг наанадаж 2600 жилийн өмнө олсон, Эйнштейний энергийн хууль болон термодинамикийн хуулиудыг аль 2600 жилийн өмнө нээгээд хэрэгжүүлчихсэн гэвэл нь үнэхээр хэгийдсэн шинжлэх ухаан юм. Ийнхүү материйг гэрэл буюу энергид хувиргах замаар хүмүүний хөгжлийг олон зуу, мянган жил удирдсан байна. Цаашлаад биеэ дэлхий дээр самачи⁵ хэлбэрээр орхиж сүнсээрээ дээд ертөнцүүдээр зорчих гэхчилэн хааяагүй оршиж, хязгааргүй наслах шинжлэх ухааныг бий болгожээ. Тийм учраас хүнийг зөвхөн махбодийн хүрээнд авч үзэж шинжлэх ухаанжуулах оролдлого хийж буй өрнийг дорнын мэргэд “буруу номтон” гэж хүлээн зөвшөөрсөн байдаг.

“Дэлхийн түүх” номонд тэмдэглэсэнээр: “Хүн өөрийн сул дорой, мөнх бус гэдгийг мэдсэн цагаас хойш амьдралын нууцын хариултыг хайх болсон байна” (*Адам Харт-Девис, Дэлхийн түүх, Монсудар хэвлэлийн газар, УБ, 2009, тал 32*).

Энэ бол хүний тухай өнөөгийн шинжлэх ухааны ойлголт. Ийм байдлаар хүмүүн бээр нэг амьдрахын хууль буюу физик биеийн онолд захирагдаж, гени, эс нь үхэхэд бүх юм дуусах тул “нэг олох нас”-ыг дураараа дургиж өнгөрөөх гүжирмэг шийдэлд хүрч, үүнийгээ улайран хэрэгжүүлэх замаар өөрсдийн “Үндсэн хууль” болох энергийн болон термодинамикийн хуулийг уландaa гишигсэн нь хүний ухамсрын доройлтыг араатны түвшинд хүртэл үүдсэн байна. Ухамсрыг шоо үзсэний гай хүмүүнд хэцүүхэн тусжээ. Эрхэм ариун чанар буюу ухамсар /Nobel Q = NQ/ дэлхийн хүний цөөнхид нь 90%, дийлэнх нь болох тааруу хүмүүст 3%, хүн төрөлхтний дундаж 10% байна (Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, Эрхэм ариун амьтад, 2010). Гэтэл энэ үзүүлэлт үхэрт 40%, нохой, зэрлэг гахай, зарим шувуунд 30%, хун, буга, орангутан сармагчинд 20%, нугас 8%, бар 4%, арслан, бүргэдэд 3% гэвэл хүмүүн биднийг ямар их гай зовлон дайраад байгаа нь ойлгогдоно. Ингэж Ч.Дарвин нарын онолоор аз болж сармагчнаас хүн бий болсонгүй, харин хүн бээр өөрөө сармагчин болж хувирахад хүрчээ.

Зөнчийнхээр: “Гай гамшиг, өлсгөлөнгийн эцэст нууц нэгэнтээ танигдана.”

Их Багш Чин Хай бээр “Энэ дэлхийн зовлон бидний мунхагаас үүдэлтэй” айлдварыг 1995 онд Сингапурт айлдахдаа: “Энэ дэлхийн гаслан зовлон нь үнэндээ дайн самуун, өлсгөлөн ч бус, харин хүн төрөлхтний мэдлэггүй мунхаг байдлаас болсон” хэмээжээ.

Тийм ээ. Сүнсийг үгүйсгэж, махбодийг хүн болгож бодитжуулснаар нэг л амьдрах насны танин мэдэхүйг шинжлэх ухааны мөрдлөг болгосон нь энэ дэлхийд, хүн төрөлхтөнд гай гамшиг хийгээд үнэн мэдлэгийн өлсгөлөнг олон зуун үүрүүлжээ. Их Багш Чин Хай болон түүний олон сая шавь өөрийгээ нээн олж, дотоодын агуу хүч чадлаа хөгжүүлснээр Дээд үнэнд хүрэхийн нууцыг эдүгээ хүн төрөлхтөнд задлан таниулж байгаа билээ.

“Гай гамшиг, өлсгөлөнгийн эцэст нууц нэгэнтээ танигдана.”

“Гай гамшиг, өлсгөлөнгийн эцэст” гэсэн нь Төгс Гэгээрсэн Их Багшийн авралаар хүмүүн бээр өөрийгээ олсноор энэ дэлхийн мунхагийн харанхуй хэмээх зовлон эцэс болохыг зөгнөхийн

хамт хүмүүн бээр өөрийгээ нээж олохыг “*нууц тайлагдана*” гэжээ. Нууц тайлагдсанаар хүмүүн бээр олон зууны төөрөгдлөөсөө салж үнэнийг олж байна.

*“The second of the last name of the prophet,
Will take Diana’s day as Her day of silent rest:
She will travel far and wide frantically,
To deliver a great people from subjection”*

*“Ирээдүйг айлдагчийн шувтаргын өмнөх нэр,
Эмэгтэй бээр өөрийн чимээгүй өдрийн адилаар Дианагийн өдрийг бий болгоно:
Тэр гайхмаар зах хязгааргүй аялж,
Хүмүүсийг үй олноор нь зовлонгоос гэтэлгэж чөлөөлнө.”*

Зөнчийн нэр болох *Nostradamus*-ын шувтаргын өмнөх нэр нь Сума гэсэн нэр байгаа нь Их Багшийн нэртэй (Сума Чин Хай) тохирч байна.

“Эмэгтэйн чимээгүй өдөр” гэдэг нь дуу хураасан дияан бясалгалыг хэлж байхын дээр Их Багш жил бүрийн сарны баярыг дияан бясалгалын өдөр болгосон байдаг. Ийнхүү *Диана (Cap)-гийн өдөр* гэдэг нь сарны бясалгалыг хэлжээ.

*“Эмэгтэй бээр гайхмаар зах хязгааргүй аялж,
Хүмүүсийг үй олноор нь зовлонгоос гэтэлгэж чөлөөлнө.”*

Их Багш бээр дэлхийн бараг бүх оронд айлчлан 400 гаруй удаа ном тайлжээ. 1999 онд зөвхөн 1 сарын дотор европын 18 оронд айлчилж байсан жишээ бий.

Ийнхүү дэлхийн олон сая хүмүүнд Авшиг хүртээжээ. Хэн нэг нь Их Багшаас Авшиг хүртвэл урагш 5-7, үүнээс ч илүү үе нь чөлөөлөгдөж, тухайн хүний өөрөөсөө хойших мөн төчнөөн үе нь гэтэлгэгдэх ба энэ үеүдэд хамаарах мал, нохой, муур нь ч чөлөөлөгдөх юм. Тухайн авшигтны ах дүү, хамаатан садан төдийгүй анд найзууд, таньдаг хүмүүс цөм чөлөөлөгдөхийг Чин Хай Багш бээр 1993 онд НҮБ-ын Женев дэх байранд “Биднээр дамжуулан үйлдэхийг Бурханд зөвшөөрчих” хэмээх ном тайлахдаа айлджээ. Гэтэлгэж чөлөөлөх гэдэг нь дээш 3 ертөнцийг давуулж ахин төрөл авахааргүй болгохыг хэлж байна. Их Багшаас Авшиг хүртсэн олон сая хүний цаана энэ олон үе, олон хүн, амьтныг хамарсан чөлөөлөлт явагдаж байна гэвэл энэ нь үгээр хэлж, тоогоор илэрхийлэх ч амаргүй үйл явц юм. Бурхан Багш бээр айлдахдаа: “Сайн цагийн Будда залрах үед түүний гэгээрлийн сургаалийг дагаж, Их хөлгөнийхэн төдийгүй бусад бүх амьтан гаслангаас ангижирна” хэмээжээ (Богд Зонхов Бодь мөрийн зэрэг, 2006, тал 236). Энэ үйл явц эдүгээ ёсоор болж, дэлхий даяар их чөлөөлөлт явагдаж байна.

Их Багшийн “Агшин зуур билэг нээгдэхийн түлхүүр” 4- р ботид тэмдэглэснээр Авшиг аваад Будда болох юм. Энэ Будда нь харсан л бол, сонссон л бол гэтэлгэдэг гэвэл энэ дэлхийд ямар их чөлөөлөлт явагдаж байгааг төсөөлж болно. Ийнхүү:

*“Эмэгтэй бээр гайхмаар зах хязгааргүй аялж,
Хүмүүсийг үй олноор нь зовлонгоос гэтэлгэж чөлөөлнө.”* гэсэн зөгнөл юутай мэргэн аж. Дараагийн зөгнөлд Их Багшийн төрөхийг болон сургааль номлол нь дэлхий даяар түгэн дэлгэрэхийг тодорхой зөгнөжээ.

“... At the eve of desolation when the perverted church is atop her most high and sublime dignity... who will deliver the people of the world from a meek and voluntary slavery and place them under the protection of Mars... The flame of a sect shall spread the world over...”

“...Цөхрөнгөө барсан тэр цаг дор замаасаа нэгэнт хазайгаад байгаа сүм хийд эмэгтэйн агуу төгс бурханлиг чанарыг оройлон дээдэлнэ... тэр бээр дэлхийнхнийг хүлцэнгүй боолчлогдлоос

аварч Марсын хамгаалалтанд авна...Савнаасаа хальж бадарсан тэрхүү гал хэдийнээ дэлхий даяар түгнэ...”

Шашны гол үүрэг болох хүмүүний гэгээрэл орхигдон, лам сүмийн ажил ойр зуурын засал төдийхнээр хязгаарлагдсан шашны бууралтын үе нь Чин Хай Багшийн төрсөн, өсөж торнисон цаг хугацаатай давхцаж байна. Их Багш Чин Хай эдүгээ нэгэнт дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн зүтгэлтэн, дэлхийн оюун санааны удирдагч бөгөөд Тэрээр 1999 онд Өмнөд Африкт болсон дэлхийн шашны их хурлыг нээж үг хэлсэн билээ.

“Тэр бээр дэлхийнхнийг хүлцэнгүйн боолчлогдлоос аварч Марсын хамгаалалтанд авна...”

Энд “хүлцэнгүй боолчлогдол” гэсэн нь оюун санааны харанхуй байдлыг хэлжээ. Хүмүүний хөдөлгөгч хүч нь сэтгэл бус, тархи бус харин ухамсар буюу сүнс болохыг мэдсэнээрээ дэлхийн сая сая хүн эдүгээ энэхүү боолчлолоос чөлөөлөгдөж байна.

“Тэр бээр дэлхийнхнийг хүлцэнгүй боолчлогдлоос аварч Марсын хамгаалалтанд авна.”

Марс гэж гал буюу гэрлийг хэлжээ. Гэрэл бол Бурханы мөн чанар бөгөөд ийнхүү дэлхийн хүмүүс Бурханы авралд багтахыг зөгнөжээ.

“Савнаасаа хальж бадарсан тэрхүү гал хэдийнээ дэлхий даяар түгнэ...”

Энд яригдаж буй “гал” бол эдүгээ нэгэнт дэлхий даяар дэлгэрсэн Их Багш Чин Хайн Гэрэл, Аялгууны бясалгал юм.

Их Багшийн цогцлоосон Гэрэл, Аялгууны бясалгалын төв болон төлөөлөл нь Африкийн 12 орны 19 хотод, Америк тивийн 15 орны 75 хотод, үүнээс АНУ-д 42, Азийн 21 орны 49 хотод, Европын 27 орны 45 хотод, Номхон далайн 2 орны 14 хотод ажиллаж, тэдгээрт янз бүрийн шашин шүтлэгтэй сая сая бясалгагч хамрагдаж байна. Их Багшийн өөрийн хөрөнгөөр байгуулсан “Суприм Мастер” телевиз нь хүмүүнлэг энэрэнгүй нэвтрүүлгийг 4 тивийн үзэгчдэд 30 гаруй хэлээр 24 цагаар өдөр алгасалгүй нэвтрүүлэн хүн төрөлхтнийг соён гэгээрүүлэх их ажлыг 5 жил (2006-2011 он) гаруйн хугацаанд цуцалтгүй гүйцэтгэсэн байна.

Их Багш Чин Хайн 5 жилийн турш дэлхийн тулгамдсан асуудлаар хийсэн телевизийн видео хурлууд нь засгийн газрууд болон үндэстний хэмжээнээс хальсан чухамхүү “Дэлхийн мэргэдийн их хурал” байсан юм.

Их Багш Чин Хай 1989 оноос хойш дэлхий дахинаа хүрч 400 гаруй удаа ном тавьснаас зөвхөн 1993, 1999 оны хоёрхон жилд гэхэд л 38 оронд уригдан 48 удаа ном тайлж байжээ. Дараагийн зөгнөлд Чин Хай Багшийн гэгээрлийг мадаггүй зөгнөж хэлсэн байна.

*“The moon in the middle of the night over the high mountain,
The young sage alone with Her mind has seen it:
Her disciples invite Her to become immortal
Her eyes in the middle, Her hands on Her breast, Her body in the fire.”*

*“Уулын оргилд мандсан шөнө дундын сар,
Билгүүн залуухан бүсгүй түүнийг оюуны мэлмийдээ тольдоно:
Шавь нар нь Түүнийг үхэшгүй мөнхлөхийг чармайна
Бүсгүйн билгийн мэлмий, мутар бас цээж, хамаг бие нь гал дотор оршино.”*

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн бясалгал нь Бурханы гэрэл (зөгнөлд гал гэж зөв нэрлэжээ) ба аялгуутай холбогдсоноор бясалгагч өөрөө гэрэл, аялгуу болон хувирах ба дотоод хүчний хийгээд билгийн мэлмий нээгдэх буюу нээгдсэн үеийн бясалгал юм. Сүнсийг ийнхүү төгөлдөржүүлснээр хүмүүн бээр үхэшгүй мөнхийн хутгийг олдог буюу энэ нь гэгээрэл болой. Ийм бясалгалын явцад сар, нар, бурханы орон, бурхад, байгаль гэх мэт нь билгийн мэлмийд үзэгдэхийг зөгнөлийн эхэнд сараар төлөөлүүлэн

*“Уулын оргилд мандсан шөнө дундын сар...
Бүсгүйн билгийн мэлмий, мутар бас цээж, хамаг бие нь гал дотор оршино.”*

Гэрэл, аялгууны бясалгалын мөн чанарт хүрч, хүмүүн оюун ухааныхаа гэрэл дотор хамаг цогцоороо мандсан байдлаар Их Багшийн гэгээрлийг уг зөгнөлд гайхмаар оновчтой тайлжээ.

*“Before the monastery a twin child is found,
Of the heroic and ancient blood of a monk:
Her fame, through a mode of language and powerful sound,
Such that one will say elect the healthy survivor of the prematurely born twins.”*

*Хос биет (хувилгаан бие) хүүхдийг сүм олзуурхаж,
Ламын баатарлиг хийгээд аль удмын цус гэгчээс нь өмнө:
Эмэгтэйн алдар хүмүүст хэл яриагаар, адистат аялгуугаар түгээж,
Цагаас урьтаж төрсөн эрүүл саруул хос биетийг тэр мөн гэж хэн нэг нь таана.”*

Зөгнөлд *хос биет* гэсэн нь Их Багшийн хувилгаан биеийг хэлжээ.

Их Багш Чин Хай хэмээх Дээд Аватар Бурхан бээр Гимлайн их ууланд 450 настай Кудачи багшийгаа олж, залуудаа Төгс Гэгээрэлд хүрсэн нэгэн билээ. Тэр бээр эцэг эх, хань нөхөр, амьдрал гэдэг нэрийн дор халхлагдан буй ертөнцийн бүх уяа хүлээсийг зориглон тасалж, амьдралыг огоорон байж хамаг амьтны тусын тулд өөрийгээ бүрэн золиосолсон билээ. Энэ бүхний эцэст Их Багш Чин Хай “Цорын ганц нууц бол бүхнийг огоорч орхих юм шүү дээ” (Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд, х 45). “Надад байгаагаас дан ганц чин сэтгэл л байлаа. Оюун санааны зам мөрд зориг шулуудсан миний сэтгэлд бодогдох юм, шаардах зүйл, санагдах хүн огт байгаагүй. Энэ дэлхийн юунд ч үл хүлэгдэх намайг тэр үед Үнэний төлөө амиа өг гэсэн бол өгөхөөр л байлаа” (Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ, х 20) хэмээн айлджээ.

Шинэ эриний залуурчийн төгс гэгээрсэн тэр мөчөөс хүн төрөлхтний их эрин үе буюу Гэрлийн эрин эхэлж 30 гаруй жил болж байна.

Гимлайгаас бууж Тайваньд оршуулгын газрын дэргэдэх жижиг сүмийн буруу харсан жижиг өрөөнд битүүмжлэн бясалгаж байхуйд нэгэн бороотой орой тэндэхийн хэсэг хүн ирж, Багшийг төгс гэгээрсэн нэгэн гэж мэргэ төлөгт буулаа гэлцэн адис хайрлахыг гуйснаар дэлхийг адислах Бурханы аврал түгэн дэлгэрсэн түүхтэй. Үүнийг зөгнөлд “Эмэгтэйн алдар хүмүүст хэл яриагаар, адистат аялгуугаар түгэнэ” гэсний хэл яриагаар гэдэгт Их Багшийн хүмүүнлэгийн их үйл хэргийг хамтатган зөгнөхийн дээр “адистат аялгуу” нь Түүний Гэрэл ба Аялгууны бясалгал дэлхийд түгэн дэлгэрэхийг зөгнөжээ.

Их Багшийн бясалгалын төв дэлхийн 77 орны 202 хотод ажиллаж байна. Их Багшийн айлдвар, сургааль номлолын 20 гаруй ном, 325 DVD, түүний уран зураг, дизайны 3 ном, 200 гаруй шүлэг, яруу найраг, дууг нь багтаасан 22 ном, CD, DVD нь дэлхийн 38 хэлээр, “Агшин зуур билэг нээгдэх түлхүүр” оршил ном нь 74 хэлээр орчуулагдан хэвлэгджээ.

*“Long awaited one will never return.
She will appear in Asia (and be) at home in Europe:
One who is issued from great Hermes
And over all the kings of the East will She grow.”*

*Удтал хүтээлгэсэн тэр бээр ирж өгөхгүй дунисаар.
Азид мэндэлж Европт суурьшина:
Агуу Гермесээс (галаас) илгээгдэх нэгэн,
Азийн бүх хаадуудаас дээгүүр өргөмжлөгдөнө.”*

Багш Чин Хай Өмнөд Вьетнамд төрж, Англи, Франц, Германд боловсрол эзэмшсэн ба Англи, Франц улсын иргэн, АНУ-ын хүндэт иргэн юм.

“Агуу Гермесээс (галаас) илгээгдэх нэгэн,”

Агуу Гермес бол эртний Грекийн Бурханы элч. Энд Бурханы элч гэгдэж буй Их Багш Чин Хай бээр 1983 онд Энэтхэг, Тайвань, Германд, 1984 онд Америкт Авшиг өгч эхэлснээс хойш бясалгал нь бүх шашин шүтлэгтэй хүмүүсийг хамарч, дэлхийн олон арван сая хүнийг оюун санааны хөгжилд удирдан залж байна .

Агуу Гермесээс (галаас) илгээгдэх нэгэн,”

Их Багш Чин Хай бол Дээд Аватар Бурхан юм⁶ (дэлгэрэнгүйг Тайлбар зүүлтийн 6-д үзнэ үү). Шри Чинмой Богдын тайлбарласнаар йог бол төгс гэгээрсэн сүнс, харин Аватар нь Оройн Дээд Их Бурханы шууд бууж ирсэн дүр юм. Аватар бол хамаг дэлхийн үйл хэрэгт оролцдог, эрч хүчтэй үйлдэж, итгэл төгс номлодог, хамгийн дээд хийгээд хамгийн доод ертөнцөд нэгэн зэрэг оршиж үйл хэргээ явуулдаг, хүн төрөлхтнийг хувирган өөрчлөх их үйлсэд хийж гүйцэтгэх чадавхи нь йогийнхоос хязгааргүй их, дэлхийд ондоо хэний ч өгч үл чадах эгнэшгүй эрхэм эрдэнэсийг соёрхон хайрлагч бөгөөд дэлхий дээр байгаа Аватар өмнө нь ирж байсан бүх Аватарын ухамсрыг илэрхийлж байдаг (Шри Чинмой Самади ба Сидхи, монгол орчуулга, 2010, тал 137-139).

Их Багш Чин Хай дээд арван нэгдүгээр ертөнцөөс бууж ирсэн Оройн Дээд Их Бурхан болохоо “From the Original Universe to Our World: True Love Never Change” хэмээх ном тайлахдаа хүлээн зөвшөөрсөн билээ (Videoconference with Supreme Master Ching Hai and SM TV staff, May 29, 2014, Los Angeles, California, USA).

Оройн Дээд Их Бурхан өөрийгээ хүлээн зөвшөөрөх нь бүх л орчлон ертөнцөд хамгийн дээд адислал байдаг гэж Бхагавад Гита номд тэмдэглэсэн байдаг. Сүнслиг ухамсрын энэ төвшин бол өмнөх аугаа гэгээрэгсдийн хүрч байгаагүй гэгээрлийн ноён оргил юм.

Ийнхүү Их Багш Чин Хай нь хүний хөгжил цаглашгүйг нотлон харуулснаараа хүн төрөлхтний түүхийн нэгэн ижилгүй суутан, ертөнц дахины гайхамшиг мөн билээ.

Йог ба Аватарын харьцуулалт

(хүснэгтийн эхний 2 нь: Шри Чинмой Богдын Самади ба Сидхи номын монгол орчуулга, УБ, 2010, тал 137-139)

Йог	Дээд Аватар нь Оройн Дээд Их Бурханы шууд бууж ирсэн дүр	Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай – Дээд Аватар
Төгс гэгээрсэн сүнс	Гэгээрсэн сүнснээс өндөр төвшинд хугас Аватар, түүнээс өндөр төвшинд Дээд Аватар байдаг.	Оройн Дээд Их Бурханы шууд бууж ирсэн дүр. Их Багш Чин Хайн айлдвар: “Төгс бүрэн хайрыг Багш биедээ тээж байдаг. Хайр юм бүхнийг угаан ариусгаж, муу бүхнийг эвдэн нурааж, хил хязгаар бүхнийг уусган сарниулдаг. Хүссэнийхээ хирээр хэрэглэж болох агуу их дотоод хүчийг хайр гэдэг. Гайхамшиг ингэж бүтдэг юм. Багш хүн өөрт нь итгэдэг хүн бүрийг чөлөөлж, Бурхадын орныг бүхэлд нь нээж, тамын орныг эвдэж чаддаг” (1, х 32-33).
зүйрлэн хэлбэл: Йог бол бут сөөг, Йог бол гол мөрөн эсвэл цөөрөм юм.	Аватар бол агуу том, асар өндөр мод, Аватар бол их далай.	Их Багш Чин Хайн айлдвар: “Их Багш бол их хүчтэй холбогдсон Оршихуй юм” (2).
цөөхөн хэдэн хүнтэй харьцах чадвартай	хамаг дэлхийн үйл хэрэгт оролцдог	Их Багш Чин Хайн айлдвар: “Их Багш энэ дэлхийд залрахуйд билиг уддисыг нь зөвхөн шавь нар нь хүртэж гэгээрээд зогсохгүй хамаг

		<p>хүн төрөлтөн ариусч, ухамсар нь тодорхой төвшинд өөдлөн дэвшдэг” (1, х 118).</p> <p>Тийм ээ, Их Багш бээр 2012 оны дэлхийн сүйрлийг зайлуулж, дэлхийн насыг уртасгаж, Авшигаар дамжуулан хүмүүнийг 9-10 хүртэл үеэр нь 3 ертөнцөөс чөлөөлж, бүх дэлхийг хамарсан оюун санааны болон хүмүүнлэгийн олон чиглэлээр ажиллаж байна.</p> <p>Их Багш бээр дэлхийн бараг бүх оронд айлчлан 400 гаруй удаа ном тайлжээ.</p>
<p>Йог аниргүйхэн үйлдэнэ</p>	<p>эрч хүчтэй үйлдэж, итгэл төгс номлодог</p>	<p>Их Багшийн цогцлоосон Гэрэл, Аялгууны бясалгалын төв болон төлөөлөл нь 77 орны 202 хотод ажиллаж, янз бүрийн шашин шүтлэгтэй сая сая бясалгагч хамрагдаж байна.</p> <p>Их Багшийн айлдвар, сургааль номлолын 20 ном, 325 DVD, түүний уран зураг, дизайны 3 ном, 200 гаруй шүлэг, яруу найраг, дууг багтаасан 26 ном, CD, DVD нь дэлхийн 38 хэлээр, “Агшин зуур билэг нээгдэх түлхүүр” оршил ном нь 74 хэлээр орчуулагдан хэвлэгджээ. Их Багшийн өөрийн хөрөнгөөр байгуулсан “Суприм Мастер” телевиз нь 4 тивийн үзэгчдэд 30 гаруй хэлээр 24 цагаар өдөр алгасалгүй нэвтрүүлэн хүн төрөлхтнийг соён гэгээрүүлэх их ажлыг 5 жил гаруйн хугацаанд цуцалтгүй гүйцэтгэсэн байна.</p> <p>2010 оны эхний байдлаар Их Багш биечилэн оролцсон “Дэлхийн энх тайвны төлөө” олон улсын даяан бясалгалыг 10 оронд 31 удаа хийсэн ба зарим даяан бясалгал нь 20000 - 30000 бясалгалчийг хамарчээ. Мөн уур амьсгалын тулгамдсан асуудлаарх олон улсын теле-бага хурлыг 12 оронд 26 удаа хийж, 30 гаруй орны 166 хоолны газрыг хамарсан ногоон хоолны олон улсын сүлжээг бий болгожээ.</p>
<p>Хүн төрөлхтний ухамсрыг дээшлүүлэх гэж оролдохдоо Йогууд заримдаа хорвоо дэлхийн мунхгийн харанхуйд автах нь бий.</p>	<p>хамгийн дээд хийгээд хамгийн доод ертөнцөд нэгэн зэрэг оршиж үйл хэргээ явуулдаг ба хамгийн доодод байлаа ч гэсэн түүний нөлөөнд автдаггүй</p>	<p>Их Багш бээр энэ дэлхийд оршин байх зуураа нэгэн зэрэг тухайлбал 12-р ертөнцийн 892 трилион 321 тэрбум залуу гарагуудыг өсч томроход нь тусалж, адислаж байгаа ба тэдэнтэй нүд ирмэхийн зуур хэдхэн секундын дотор холбогдон адислаж байгаа билээ (3).</p>
	<p>хүн төрөлхтнийг хувирган өөрчлөх их үйлсэд хийж гүйцэтгэх чадавхи нь йогийнхоос хязгааргүй их</p>	<p>Их Багш Чин Хайн айлдвар: “Сэтгэлийн Авшиг хүртэх нь хамаг амьтныг гэтэлгэж байгаа хэрэг. Аяндаа хамаг амьтныг гэтэлгэнэ. Учир нь шавь нар Багшийнхаа хүчийг түгээж энэхүү ертөнцийг цэвэршүүлж байгаа юм (4, х 185).</p> <p>Авшиг хүртсэнээр 5, 6, 7, түүнээс ч олон үеийн хамаатнууд чинь чөлөөлөгдөнө. Тэднийг биеэ орхисны дараа Багш өндөр төвшинд тэдэнд зааж сургах болно. Та нар хэрэв хүсэхгүй бол эцэг эх тань хэзээ ч эргэж төрөхгүй. Харин тэд энэ дэлхийгээс нэгэнт явчихсан бол хэд дэх үе гэдэг нь хамаагүйгээр чөлөөлөгдөх болно. Энэ насандаа хэнд хайртай байсан, хэнийг энэрэн хайрлаж байсан бүх хүмүүс, бүр муур, нохой нь хүртэл ач тусыг нь хүртэнэ. Авшиг бол маш агуу хүч юм (5).</p> <p>Арьяабалын бясалгалаар зөвхөн та өөрөө чөлөөлөгдөөд зогсохгүй найз нөхөд, хамаатан садан, хойч үе тань бас чөлөөлөгдөнө. Тэд энэ дэлхийгээс явсан бай, яваагүй ч бай хамаагүй</p>

		чөлөөлөгдөнө. Тэднээс чинь хэн нэг нь тамд байсан ч чөлөөлөгдөнө. Их хүчийг үгээр илэрхийлэх аргагүй. 7-9 үеэ аврах боломжтой. Бас огт мэдэхгүй өнгөрсөн элэнц дээдсээ, мөн хэзээ төрөх нь тодорхойгүй хойч үе тань цусан холбоогоор дамжаад чөлөөлөгдөнө” (6).
	дэлхийд ондоо хэний ч өгч үл чадах эгнэшгүй эрхэм эрдэнэсийг соёрхон хайрлагч	Их Багш Чин Хайн айлдвар: “Авшиг бол сая жилд ганц тохиох боломж юм (ХБНГУ, Гамбург, 1995.8.25-27). Авшиг хүртэх нь орчлонгийн хамгийн том бэлэг мөн” (7).
	Дэлхий дээр байгаа Аватар өмнө нь ирж байсан бүх Аватарын ухамсрыг илэрхийлж байдаг.	Шри Чинмой Богдын бичсэнээс үзвэл дэлхий дээр өмнө нь Будда, Иус Христ, Кришна, Шри Рама Кришна болон бусад Аватарууд буусан байна. Тэгэхээр Их Багш Чин Хай бол тэдгээр бүх Аватаруудын ухамсрыг илэрхийлж байна гэсэн үг юм. Өөрөөр хэлвэл Тэд бүгдээрээ нэг дүрээр буусан гэсэн үг. Ийнхүү олон тэрбум Эрхэм ариун чанар (эрхэм ариун чанар хүн төрөлхтний дундаж 10%, дийлэнх нь 3%), 40 сая Хайрын чанар, хэдэн тэрбум Диваажингийн чанарыг цогцлоосон аугаа үйлстэн, Оройн Дээд Их Бурхан, Дээд Аватар эх дэлхийд, хүн төрөлхтний дунд залран буй.
Дээдгэгээнтэй /Оройн Дээд Их Бурхан/ өөрийн дураар харилцах чадвар ихэнх Йогд байдаггүй. Өндөр дээд ухамсарт хүрч Бурхантай холбоо тогтоохын тулд Йог хүнд хоёр гурван цаг шаардагдана. Бурхантай Бурхантай нүд ирмэхийн зуур холбоо барих чадвар Йог хүнд үгүй.	Аватар гэдэг нь Дээдгэгээнтэй /Оройн Дээд Их Бурхан/ өөрийн дураар харилцах чадвартай Дээдгэгээний шууд бууж ирсэн дүр юм. Зөвхөн Аватар л Бурхантай ийм холбоотой байдаг. Аватар бол жирийн хүний ёсоор хэлж ярьж, идэж ууж, амьсгалж амьдардаг. Гэвч өндөр дээд ухамсарт хүрсэн үед нь хэрэв та түүний тэр ухамсрыг зэрвэхэн ч гэсэн харж чадвал хамаг амьдрал тань түүний өлмийд хүлцэнгүй боол мэт сөхрөх болно. Тэгээд хөөгдөж туугдаж, хөлд нь өшиглүүлсэн ч та түүнийг үнэнч нохой мэт дагаж явна. Яагаад гэвэл энэ дэлхийд ондоо хэний ч өгч үл чадах эгнэшгүй эрхэм эрдэнэсийг түүний дотроос та олсон юм. Аватарын агуу өндрийг бүдэг бадагхан, ирмэх агшны зуур ч атугай харж чадахын тулд аливаа хүн сэтгэл зүрхний асар өндөр ухамсрыг олсон байх шаардлагатай. Аватарын ухамсрыг хэрхэвч тайлбарлаж, илэрхийлэх аргагүй.	Их Багш Чин Хайн айлдвар: “Их Багш Авшиг хүртээх үедээ таньг дээш хол татна. Авшиг хүртсэний дараа танд хуримтлагдсан үйл үр байхгүй болох учраас хэрэв өөрөө хүсэхгүй л бол дахин төрөл авах хэрэггүй болно (8, х 135). Энэ бол агшин зуур билгийн мэлмий нээгдэж Мөн чанартайгаа учрах агшин зуурын гэгээрэл юм. Сэтгэлийн Авшиг хүртмэгц Бурхан болно. Та нар бүгд Бурхад. Энд байгаа хүмүүсийн дотор Бурхан болоогүй нэг ч хүн байхгүй. Гэвч өөртөө итгэлгүй учир Бурхан биш байна. Туршлагажаад ирэхээрээ, хожим олон барилдлага нийлмэгц Бурхан болсноо мэднэ. Хэзээ Бурхан болохоо хүлээх хэрэггүй. Авшиг хүртмэгц Бурхан болно (4, х 135). Сайн бясалгаж бүрэн гүйцэд дияанч хүчтэй болоод хамаг амьтныг гэтэлгэх үед Бурхан болсноо мэднэ (4, х 138). Авшиг хүртээд орхигдсон хүн гэж байдаггүй. Оройн Дээд Их Бурханы Вант Улстай холбогдоогүй авшигтан гэж байхгүй. Надаас Авшиг хүртээд юу ч үгүй хоосон хоцорсноос тэнгэр нурж унах нь хавигүй хялбар” (9).
	Аватар Гүрү (Багш)-тэй болно гэдэг хүний амьдралд тохиож болох хамгийн эрхэмээс ч эрхэм ерөөлт учрал билээ. Аватар дүрээр бууж ирсэн Бурхан бол Бурханаас Өөрөөс нь хавьгүй их нигүүлсэнгүй байдаг. “Хэрэв би ямар нэг буруу хэрэг хийчихвэл Бурхан намайг шүүж, үйлийн үрийг минь эдлүүлэх болно. Гүрү /Аватар/ тийм биш ээ. Эрхэм дотны шавь нараа Тэрээр зөвхөн энэрч хайрлаж л чаддаг юм. Тийм ч учраас надад оногдсон шийтгэлийг Гүрү минь өөртөө хүлээдэг юм” гэж шавь хэлнэ.	Их Багш Чин Хайн айлдвар: Би энэ насанд чинь чөлөөлнө гэж амласан (10). Би” та нарт гэгээнтэн байхыг тань, Диваажин дахь суудлыг тань, илүү билиг ухаан, хайрыг олохыг тань батлан даана (11). Та нар энэ дэлхийд буцаж ирж зовохгүй, тамд унахгүй, амьтны төрөл ч авахгүй, гарцаагүй дээшээ явна гэдгийг би амлаж байна. Багш бээр авшигтан шавийг 24 цаг унталгүй харж хандах тул санаа зовох явдалгүй (12). Шавь урагш ганц алхам хийхэд Багшийн хүч бидэнд туслах гэж зуун алхам хийнэ (8, х 292). Тиймээс жаахан чин сэтгэлээр өчүүхэн чармайлт гаргах л юм бол Их Багш бүхнийг

	Хэрэв эрэлчин хүн чин сэтгэлийнхээ угаас, асар их хүчээр Бурханд залбирч, Бурханыг дуудан уйлах аваас Бурхан бээр түүнд шийтгэл хүлээлгэлгүй өршөөл хүртээж болох юм. Харин Аватар Гүрүтэй шавийн хувьд түүний хүлээх учиртай шийтгэлийг нь Гүрү шавийнхаа өмнөөс хүлээх болно.	авралдаа багтааж бусад юмыг тооцохгүй. (1, х 301). Шавь бие махбодоо орхихын өмнө, эсвэл Багш тань биеэ орхихоос өмнө та хаана байсан тэр төвшнөөс эхлэн таныг дээш авч явах нь Багшийн үүрэг юм. Багш таныг аль хүрэх төвшинд тань хүргэж дэмжих бөгөөд дээш дээш нь үргэлжлүүлэн замчилсаар байх болно (8, х 309). Хэрвээ та мянган жилийн өмнө Багштай барилдлага тогтоосон бол хичнээн цаг хугацаа өнгөрсөн ч хамаагүй Тэр танд санаа тавьсаар байх болно” (1, х 112-113).
	Аватарын хувьд юм бүхэн тэс одоо. Аватар бол Бурханы шууд бууж ирсэн дүр болохоор ямар ч байдлаараа төгс төгөлдөр. Яагаад гэвэл тэр Оройндээдийн төлөөлөл билээ. Ондоо Багш нар ч бас Бурханы дүрүүд боловч эрдмийн зэрэгтэй их сургуулийн багш, цэцэрлэгийн багш хоёр хичнээн их зөрүүтэй байдаг шиг Аватар болон Гэгээрсэн Багш нар хичнээн их ялгаатайг ухаарах хэрэгтэй.	Их Багш Чин Хай бээр үнэндээ урьд өмнө буусан аль ч Аватарын хийж чадаагүйг эдүгээ бүх дэлхийг, хүн төрөлхтнийг, хамаг амьтныг хамруулан хийж, чухамхүү Оройн Дээд Их Бурханыг ертөнцөд жинхэнэ ёсоор тунхаглаж байгаа билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн бүтээлүүдээс хүснэгтэд ишилсэн болно. Үүнд:

1. Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ
2. Our Thinking Can Change the Universe, February 19, 2009
3. From the Original Universe to Our World: True Love Never Change, Videoconference with Supreme Master Ching Hai and SM TV staff, May 29, 2014, Los Angeles, California, USA
4. Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр, боть 3
5. Let God Serve Through Us, April 20, 1993, Geneva
6. The Suffering of This World Comes from Our Ignorance, Singapore, 1995, video 467
7. Авшиг хүртэх бол орчлонгийн хамгийн үнэт бэлэг мөн, Флорида, 2001.6.11
8. Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд
9. Эхлээд Эзэн Бурханы Вант улсыг эрж ол, Сидней, 1993.3.17
10. Их Багшийн жинхэнэ шавь байхуй, Испани, Мадрид, 2008
11. Love Is Important, February 14, 2009, France
12. Enlightenment is the Key to Everything, April 10, 1993, Colorado, USA, Denver

Агуу Гермесээс (галаас) илгээгдэх нэгэн, Азийн бүх хаадуудаас дээгүүр өргөмжлөгдөнө.”

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн эх дэлхий хийгээд хүн төрөлхтний төлөөх энэрэнгүй үйлсийг үнэлж Түүнд Дэлхийн энх тайвны шагнал (1993), Дэлхийн оюун санааны удирдагч шагнал (1994), Дэлхийн хүмүүнлэг иргэн шагнал (1994), 2006 оны Гусигийн Энх Тайвны Шагнал, 27 дахь Теллигийн шагналын тэргүүн байрын мөнгөн цом (2006), Лос Анжелесын хөгжмийн долоо хоногийн сайшаал (2002) зэрэг шагнал хүртээжээ.

Их Багш Чин Хайд АНУ-ын Ерөнхийлөгч Брак Обама Сайн үйлсийн төлөөх Ерөнхийлөгчийн шагналыг 2010 онд хүртээжээ.

1993 онд Хавайн Хонолулугийн захирагч 10-р сарын 25-ныг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн өдөр” болгож, Их Багшид Дэлхийн энх тайвны шагнал гардуулахын хамт Их Багшийн цээж баримлыг Хонолулу хотод босгосон ба 1993 онд Түүнийг АНУ-ын Хавай, Аризона, Калифорни зэрэг 5 муж улсын Хүндэт иргэнээр өргөмжилжээ. АНУ-ын Иллинойс, Висконсин, Иова, Канзас, Миссури, Миннесота зэрэг 6 муж улс 1994 оны 2-р сарын 22-ныг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн өдөр” болгон зарлаж, цээж баримлыг нь эдгээр 6 муж улсад босгож, Түүнд “Дэлхийн оюун санааны удирдагч” шагналыг гардуулах ёслол Чикагод болж, АНУ-ын Ерөнхийлөгч Клинтон, Буш, Рейген нар Их Багш Чин Хайд баяр хүргэж мэндчилгээ илгээсэн байна (Awards Reseived by Supreme Master Ching Hai Over the Years).

Википедиа лавлахад: “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол соёл, зан заншлын элдэв ялгаа саадыг үл ажран хайр энэрлээ түгээж байдаг дэлхий дахинаа суу алдар нь түгсэн оюун санааны аугаа залуурч, уран бүтээлч, хүмүүнлэг үйлстэн билээ” гэж бичжээ.

Хүн төрөлхтний оюун санааны удирдагч, соён гэгээрүүлэгчийн төдийгүй хүмүүнлэгийн хийгээд цаг уурын өөрчлөлтийн тулгамдсан асуудлаар хийж буй Их Багш Чин Хай хэмээх түүхэн хувь хүний асар далайцтай ажлууд нь зөнчийн зөгнөснөөр үнэндээ Азийн хаадаас ч давж дэлхийн хэмжээнд хүрчээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дуу хөгжмийн “Дуу хөгжмөөр энх тайван, эв нэгдэлд хүрэхүй” хандивын концертыг АНУ-ын Лонг Бийч (1996), Вашингтон (1997), Холливуд (1998)-д тоглож, орлогыг нь өнчин хүүхдийн асрамжийн газруудад хандивлажээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай аливаа хэлбэрийн өргөл барьц, хандив авдаггүй, зөвхөн өөрийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг хандив тусламж болгон түгээдэг юм. Их Багш Чин Хай 1989-өөс 2010 оны 2 дугаар сарын байдлаар дэлхийн 1100 гамшгийн тохиолдолд хүмүүнлэгийн зориулалтаар хувиасаа 20 сая америк доллар хандивлажээ. Үүний дотор Монголд зориулж үерийн хохирлыг барагдуулахад 20 000 ам.доллар, мод тарихад 20 000 ам.доллар, монголын уран бүтээлчдийг дэмжихэд 35 000ам.доллар хандивлажээ.

Их Багш бээр уур амьсгалын өөрчлөлтийн тулгамдсан асуудал хийгээд заналхийлж байгаа аюулыг хүн төрөлхтөнд 30 жилийн өмнөөс сануулж, дэлхийг аврах боломж, арга замыг нь анхааруулан хэлж, зааж, эх дэлхийгээ аврах хөдөлгөөнийг өөрийн биеэр удирдан зохион байгуулж, улмаар дэлхийн хэмжээний далайцтай ажлуудыг хийсний дотор 2010 оны эхний байдлаар 30 гаруй орны 166 хоолны газрыг хамарсан ногоон хоолны олон улсын сүлжээг бий болгож, дэлхийн цагаан ба ногоо хоолтны тоо хоёр дахин нэмэгдэж 1.5 тэрбумд хүрсэн ба уур амьсгалын тулгамдсан асуудлаарх олон улсын теле-бага хурлыг 12 оронд 26 удаа хийсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Өөрийн нэрэмжит шагнал болох “Эх дэлхийн гарамгай удирдагч”, “Эх дэлхийн гарамгай энэрэнгүй үйлстэн”, “Эх дэлхийн гарамгай Баатарлаг Үйлстэн”, “Эх дэлхийн гарамгай үнэнч шударга сэтгэлтэн”, “Эх дэлхийгээ гарамгай хамгаалагч”, “Эх дэлхийн гарамгай оюун ухаантан”, “Эх дэлхийн гарамгай зохион бүтээгч” зэрэг шагналуудыг 2006 оноос бий болгосон ба иргэн, олон нийтийн байгууллагын зүгээс дэлхий дахинд сайн сайхныг түгээн дэлгэрүүлэхийн төлөө хийж буй үйл хэрэг, үлгэр дууриалыг урамшуулан жил бүр олгож байна.

Их Багш Чин Хай дэлхийн түүхэнд урьд өмнө мэдэгдээгүй оньсого мэт байсан олон зүйлийн нууцыг тайлсаны дотор Вермудын гурвалжин, пирамидууд, нар, нарны аймгийн зарим сөнөсөн гарагийн нууц, дэлхий дээрх сүнслиг адислалт шулуунууд, мөн диваажингийн үүд болон тамын үүд, гарц, дэд гарцуудыг улс орон бүрээр нарийн хэлж, муу нөлөөнөөс хэрхэн зайсхийх аргыг ч зааж өгсөний дээр хүн болон амьтны үндсэн чанарууд болох бурханлиг чанар, хайрлиг чанар, эрхэм ариун чанар, нинжин чанар, сайн муу чанар, адислах хүч, хүний үнэ цэн (хүний төрлийг олж авахад: 9,2 зиллион зиллион оюун санааны оноо шаардлагатай) болон бидний голлож эрхэлдэг ажил үйлдлээс олох ба алдах буян, нүглийн сүнслиг оноо зэргийг хүн төрөлхтөнд тайлж өгсөн билээ.

*“Libra will see the Western lands to govern,
Holding the rule over the skies and the earth:
No one will see the forces of Asia destroyed,
Not until seven hold the hierarchy in succession.
The year the great seventh number is accomplished,
Appearing at the time of the games of slaughter:*

*Not far from the age of the great millennium (2000),
When the dead will come out of their graves,
Sooner and later you will see great changes
From extreme horrors and vengeance,
For the moon is led by its angel,
The heavens approach the balance.”*

*“Жинлүүр барууны орнуудыг удирдаж гэмээнэ,
Тэнгэрийн болон дэлхийн хуульд нийцүүлнэ:
Азийн хүч сулрахыг хэн ч үзэхгүй,
Ямартаа ч долоо амжилттай журамлагдах хүртэл.
Их долоо дахь тоо тохиох жил,
Амьтны амь хөнөөж тоглогчидтой нүүрэлдэж:
Их мянган\2000\ -аас хэлгүй,
Үхдэлүүд булинаасаа өндийхүй дор,
Эрт орой хэдий боловч та их өөрчлөлтийг үзэх болно
Хэтийдсэн тэрхүү аймшиг, гаслан гамшигийн дараа,
Сар Сахадсан тэнгэрийн залуурт эргэн очиж,
Диваажин амсхийнэ.”*

*“Жинлүүр барууны орнуудыг удирдаж гэмээнэ,
Тэнгэрийн болон дэлхийн хуульд нийцүүлнэ.”*

Жинлүүр гэдэг нь Их Багшийг хэлжээ. Жинлүүрийн орд тохиосон 1972-1984 онд Их Багш Чин Хай хүнтөрөлхтөнд өөрийн номлол сургаалиа хайрлаж эхэлсэн ба 1972 онд Тэрээр Европт суурьшиж, 1983 онд Энэтхэг, Тайвань, Германд, 1984 онд АНУ-д айлчилж Авшиг хүртээж эхэлсэн байна. Авшиг гэдэг нь хүмүүний билгийн мэлмийг нээж сүнснийг хөгжүүлэх адислал, үйл ажиллагаа юм. Ийнхүү 1983 оноос эхлэн дэлхийн хүний хөгжил, үйл ажиллагаа нь тэнгэрийн хуулинд зохицон явагдах боломж нээгдэж, энэ нь эдүгээ дэлхий дахиныг хамарч байна. Их Багш 1995 онд Германы Гамбургт айлдахдаа “Авшиг бол сая жилд ганц тохиох боломж”, 2001 онд АНУ-ын Флоридад “Авшиг хүртэх нь орчлонгийн хамгийн том бэлэг”, “Хэн нэг нь Их Багшаас авшиг хүртвэл урагш 5-7 үе нь чөлөөлөгдөж, үүнээс ч илүү үеийг, өөрөөсөө хойших мөн төчнөөн үеийг гэтэлгэх ба энэ үеүдэд хамаарах мал амьтан, бас тэдний ах дүүс төрөл садан, мөн найз нөхөд бүгд чөлөөлөгдөнө” гэж Их Багш Чин Хай бээр 1993 онд Женевт “Биднээр дамжуулан үйлдэхийг Бурханд зөвшөөрчих” ном тайлахдаа айлдсанаас үзвэл энэ нь улс орнуудыг удирдахтай жишимгүй, хүн төрөлхтний хувь заяаны жинхэнэ удирдлага болох нь харагдаж байна.

Тэнгэрийн хууль гэдэг нь Хайрын хууль, Үйл үрийн хууль бөгөөд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай айлдахдаа: “Хайр юм бүхнийг угаан ариусгаж, эвдэн нурааж, хил хязгаар бүгдийг уусган ариусгадаг. Энэ агуу их дотоодхүчийг яагаад хайр гэж нэрлэдэг вэ? Яагаад гэвэл энэ хайр хамаг нүгэл хилэнцийг маань уучлан өршөөж, угаанариусгадаг юм. Урьд өмнө ямар муу үйл хийсэн нь хамаагүй. Хайранд нүгэл хилэнц, зааг хязгаар, өнгөрч улирсангэж үгүй, зөвхөн одоо л гэж бий. Энэ хайртай холбогдож, үүнийг мэдрэх л юм бол нялх хүүхэд мэт ариусдаг. Тиймээс л хайр гэж нэрлэдэг юм. Есүс энэ л хайрын хүчээр шавь нарынхаа нүглийг цайруулсан. Будда энэ л хайрын хүчээр хүмүүнийг Бурханы оронд нь буцааж хүргэсэн. Бид бүх үзэл бодлоосоо салчихвал тэр бурханлиг хайр өсөн цэцэглэх болно. “Би” үгүй болмогц Будда шиг энэрэнгүй болно. Гайхамшиг ингэж бүтдэг. Учир нь хайрын хууль нь бусад бүх, үүний дотор Үйл үрийн хуулийг ч даван туулж чаддаг. Тийм болохоор Багш бол өөрт нь итгэдэг хүн бүрийг чөлөөлж, Бурхадын орныг бүхэлд нь нээж, тамын орныг бүхэлд нь эвдэж чаддаг билээ” хэмээн айлджээ (Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ, 6 дахь хэвлэл, 2007, тал 33). Энэ айлдварт тэнгэрийн хууль гэж юу болох, хэрхэн хэрэгжихийг нь, мөн Бурхан гэж хэн болохыг нэгд нэгэнгүй айлджээ. Их Багш Чин Хай бээр эдүгээ дэлхийн оюун санааны хөгжлийн удирдлагыг гартаа авч менежментийн дараах аргаар хэрэгжүүлж байна: “Ертөнцийг шүүмжилж, хүмүүсийг засах гэж

оролдсоор бүр залхаж ядарсныхаа эцэст миний засаж залруулах хүн нь би өөрөө юм байна гэдгийг ойлгосон (“Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ” 6 дахь хэвлэл, 2007, тал 39), өөрөөр хэлвэл ертөнцийг өөртөө тохируулах бус ертөнцтэй өөрийгээ зохицуулах юм.

“Тэгээрснийхээ дараа би ертөнцийн хамаг амьтан бие биетэйгээ шүтэн барилдсаныг олж харсан билээ. Бидний мөн чанар нэгэн ижил, бид бүгдээрээ нэгдмэл юм” (мөн тэнд, тал 154), өөрөөр хэлвэл миниймсрэгч “Би” үгүй, ялгаварлал үгүй, хүчирхийлэл үгүй элбэрэл журам.

Улс орны удирдлагыг тэнгэрийн болон дэлхийн хуульд нийцүүлснээр “Азийн хүч сулрахыг хэн ч үзэхгүй”, энэ байдал “Ямартаа ч долоо амжилттай журамлагдах хүртэл.” үргэлжлэх болж байна.

“Азийн хүч сулрахыг хэн ч үзэхгүй” гэсэн нь өмнө нэгэнтээ тайлбарласанчилан өрнө, дорнын шинжлэх ухааны болон уламжлалт гүн ухааны байр суурийг хэлж буй бөгөөд Их Багш Чин Хайн сургаал номлол дорныг улам алдаршуулахыг зөгнөжээ. Энэхүү алдаршуулал нь

“Ямартаа ч долоо амжилттай журамлагдах хүртэл.” явагдах нь.

Зөгнөлийн дараагийн хэсэгт дэлхийг сүйрэлд хүргэх аюул, түүний шалтгааныг, тухайлбал: тонилгосон амьтдынх нь хүүр өндөлзөн босч амь хөнөөж тоглогч нартайгаа нүүр тулснаар хэтийдсэн аймшиг, гаслан гамшигийг үүднэ хэмээн зөгнөжээ. Өөрөөр хэлбэл, амьтдыг үй олноор нь алж хядсаны гайгаар дэлхийд хэтийдсэн их аймшиг, гаслан гамшиг нүүрлэх болж таарч байна.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын тайлан болох “Мал аж ахуйн урт сүүдэр”

(Long shadow of animal) номонд бичсэнээр дэлхийн хүний хэрэглээг хангахын тулд жилд 56 тэрбум мал, гахай нядалж, АНУ дангаараа цагт 1 сая шувууны амь хороодог гэвэл цаана нь шувуу, загас хичнээн тэрбумаараа бидний гарт амиа алдаж байгаа балмад явдлын хариуцлага дэлхийд, хүн төрөлхтөнд хэрхэн ирэхийг зөгнөжээ. “Хэрэв бид бусдын амь насыг хохироохгүй бол бидний амь нас ч аюулд өртөхгүй. Энэ бол учир шалтгаан, үр дагавар, үйл үрийн хууль юм” гэж Их Багш Чин Хай “Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ” номондоо айлдсантай Нострадамусын зөгнөл ойролцоо утгатай байна. Их Багш Чин Хай 1994 онд “Шүүлтийн өдрийн сүйрлээс эх дэлхийгээ аваръя” сэдвээр Токиод ном тавихдаа: “Хэрвээ бид амьдралын хэв маягаа өөрчилж, цагаан хоолтон болж, мод тарьж эхэлвэл дэлхий маань 10 жилийн дотор л одоогийнхоос өөр болж бид аврагдах болно” хэмээн айлдаж уриалсан боловч энэ их буяныг хүн төрөлхтөн нэгэнт алдсан билээ. Их Багш бээр “Хүн бүр цагаан хоолтон болвол хүн төрөлхтний наанадаж 80% нь аврагдана. Эс бөгөөс 80% нь энэ дэлхийг орхиж явах болно” (DVD747) гэж

айлдсан бол “Та дэлхийг аврах асуудлыг цагаан хоолтой холбон тайлбарлах юм. Өөр арга зам юу байна вэ” гэсэн Английн радиогийн сурвалжлагчийн асуултанд Тэрээр “Өөр арга зам гэж үгүй” хэмээн нэг мөр хариулсан байна. Их Багш 2008 онд Америкийн Байгаль орчны дуу хоолой радиогийн сурвалжлагчийн цагаан хоол дэлхийг аврах нь хир баталгаатайг асуусан асуултанд “баталгаатай” гэж хариулсан бол Ирландын East Cost радиогийн сурвалжтай ярилцахдаа ядаж хүн төрөлхтний гуравны хоёр нь ногоо хоолтон болвол байдал дээрдэнэ гэжээ.

Бээжингээс 50 км-д олдсон газар доорх номын санг тайлснаас үзвэл Бурхан Багшийн “Хүнсэндээ мах хэзээ ч бүү хэрэглэ. Үдээс хойш хоол унд бүү зоогло. Долоо хоногт 1 өдрийг өлөн өнгөрөөж бай” гэсэн айлдвар байгаа юм байна.

Тэгэхээр зөгнөлд дурдсан “хэтийдсэн аймшиг, гаслан гамшиг”-ийн шалтгааныг махны хэрэглээтэй холбосон нь Бурхадын болон зөгнөгчийн лүндэнгүүдтэй таарч байна. Эл гамшиг тохиох хугацааг “Их мянган /2000/-аас хойш холгүй,” “их долоо дахь тоо тохиох жил” гэсэн зөгнөл байна. Энэ хэдэн он байж болох вэ?

Энэ асуултын хариуг олохын тулд дэлхий дээр чухам юу гээч болоод байна вэ гэдэгт товч хариу хайя.

Их Багш Чин Хай бээр эх дэлхийг болон хүн төрөлхтнийг аврах боломжийг байнга сануулж, арга замыг заасаар ирсэн билээ.

Бурхан Багшийн “Чулууны бичиг” хэмээх дээр дурдсан лүндэнд “Ертөнцийн төгсгөл ирэх цагт ой модыг улаан түймэр идэж, газар төдийгүй хот тосгодыг их ус эзлэх болно. Байгалийн гамшиг ертөнцийг мөхөөж, газар дэлхий амьгүй болно” гэсэн бол хугацааг:

Хүний мөс чанар газар доогуур орж, муугийн үйлийг таригчид шоргоолжноос олон болж,

хүйтэн сэтгэлтнүүд ертөнцийг эзэгнэх үед” гэсэн нь одоогийн бидний үетэй таарахаар байна. Зөгнөл ба Бурхадын лүндэн нь дэлхийд гамшиг болох тухайтад болон түүний шалтгаан, хугацааны тухайд ойролцоо байна. Юу хэлээд байна вэ?

Махны хэрэглээ нь дэлхийн дулаарал, улмаар бүх аюул гамшгийн уг сурвалж болж буйг Их Багш Чин Хай 30-аад жилийн тэртээгээс сануулсаар байгаа ба харин шинжлэх ухаан хэдхэн жилийн өмнө судалж тогтоогоод байна. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас эрхлэн хэвлэсэн “Мал аж ахуйн урт сүүдэр” (Long shadow of animal, 2007), “Дадал зуршлаа өөрчилцгөөе” (Kick the habit, 2008) номонд тэмдэглэсэнээр нүүрс хүчлийн хийнээс 300 дахин хүчтэй дулааруулагч азотын дутуу ислийн 65%, 23 дахин хүчтэй дулааруулдаг метан хийний 37% нь малаж ахуйд ногддог, нүүрс хүчлийн хийнд шилжүүлснээр мах хэрэглэдэг 1 хүн жилд 6,7 тонн, цагаан хоолтон 1,2 тонн, ногоогоор хооллогч 190 кг дулааруулагч хий ялгаруулдаг байна. Дэлхийг бид ингэж дулааруулжээ. Энэ гамшиг дэлхийг аварсаны хойно одоо ч урьдын хэвээр байсаар байна.

“Их мянган \2000\-аас хойш холгүй,” гэсэн зөгнөл нь 2016 он байж болох бөгөөд энэ нь 2 дахь их мянганы дараах 1 ба 6 гэсэн тооны нийлбэр долоо болж байгаа нь “их долоо дахь тоо тохиох жил” гэсэн зөгнөлийн тайлал байж болох юм. “Эрт орой хэдий боловч та их өөрчлөлтийг үзэх болно” гэсэнээр энэ өөрчлөлтийг бүх хүн үзэх боловч “өөрчлөлт” харамсалтай нь “Өгүүлийгүй хэтийдсэн аймшиг, гаслан гамшиг” байх нь ээ. Ийнхүү “Их долоо дахь тоо тохиох жил” бол 2016 он (1 + 6 = 7) байх магадлалтай бөгөөд дээрээ овоолгоостой их нүгэл хилэнцийг сэгсэрч ариуссан шинэ дэлхийн эхлэл байж болох юм. Дэлхий шинэ хэмжээст шилжсэнээр уг асуудал шийдэгдэх юм. Ийнхүү “их” гэсэн долоо дахь тооны тодотгол нь: 1. Дэлхийг донсолгосон их сүйрэл 2. Дэлхий өөр хэмжээст шилжих гэсэн хоёр том асуудлыг сануулж байж болох юм.

“Сар Сахиусан тэнгэрийн залуурт эргэн очиж Диваажин амсхийнэ.”

Дэлхий (Сар) дээд гарагуудын хэмжээст хүрч дэвшихийг “Сахиусан тэнгэрийн залуурт эргэн очно” гэжээ. Ийнхүү дэлхийн зовлон дуусч, улмаар дэвшин орчлонгийн төлөвлөгөө хэрэгжихэд Диваажин амсхийх нь байна.

Оройн Дээд Их Бурхан, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай 2012 оны 1-р сард дэлхийн насыг 22,4 жилээр сунгасан бол мөн оны 4-р сар гэхэд 58 жилээр (Дэлхийг дэвшүүлэхүй, 2012.4.7, Франц) сунгасан юм. Үнэндээ Их Багш маань дэлхийг, хамаг амьтныг аврахад хэзээд бэлэн байсан боловч хүн төрөлхтний зүгээс Түүнийг үйлийн үрдээ оролцуулах зөвшөөрөл өгөгдөөгүй ба нэгэнт хүлээх цаг үлдээгүй тул Багш бээр дэлхийтэй ярьж хүсэлтийг нь асуухад “дэлхий ээж маань сүйрэхийг хүсээгүй” нь Диваажингийн зүгээс дэлхийн насыг сунгахыг зөвшөөрөхөд хүргэсэн хэрэг.

Алтан эриний 9 дэх жил (2012 он) хүн төрөлхтний түүхэнд мартагдашгүй он байсан юм. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай 2012 оны 3-р сарын 23-наас 4-р сарын 9-нд олон улсын дияан бясалгалыг Европт хийх үеэр Тэрээр дэлхийн насыг 50 жилээр сунгасан тухай гайхалтай мэдээлэл хийсэн билээ. Их Багш: “Дэлхийн төлөө бясалгаснаар цаашид насыг нь ойрын хугацаанд зуу, мянган жилээр сунгах боломжтой” гэж айлдсан билээ (Be One with God and Heaven at All Times, A Special Gathering with Supreme Master Ching Hai, Compiled by USA News Group, <http://www.godsdirectcontact.org.tw>).

2012 оны 12-р сарын 22-д Их Багш Чин Хай бээр “Supreme Master” телевизийн ажиллагсадтай телеконференц хийхдээ дэлхийн нас 12-р сарын 18-нд 8331171 /8 сая жил/ жилээр сунгагдан адислагдсаныг, цаашид Өөрийн гүн бясалгалаар улам адислахаа дэлхий дахинд мэдэгдсэн билээ (Be One with God and Heaven at All Times, A Special Gathering with Supreme Master Ching Hai, Compiled by USA News Group, <http://www.godsdirectcontact.org.tw/>).

Ийнхүү дэлхийн насанд санаа зовох хэрэг үгүй боллоо. Одоо юу санаа зовоож байна вэ?

Хэдийгээр Оройн Дээд Их Бурхан, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн авралаар 2012 он аврагдаж, дэлхийн нас уртасч, зөгнөлийн “2014” байж болох он хойшлогдсон хэдий ч энэ нь хүмүүн бидний үйлийн үр дууссан гэсэн хэрэг огт биш, бид өр төлөөсийг орчлонгийн хуулийн дагуу төлөх нь гарцаагүй бөгөөд ердөө цаг хугацааны л асуудал юм.

Тийм учраас Их Багш бээр айлдахдаа: “Дэлхийн нас уртсах нь дэлхий сэрүүсч хөрсөн, дулаарал зогссон гэсэн үг биш. Хүмүүн бид буруу үйлдсээр л бол дэлхийг сөнөөх хүч хэвээр байсаар л байна (*Дэлхийг дэвшүүлэхүй, 2012.4.7, Франц*).

Атлант, Лимур, Му гэхчилэн их хөгжсөн төрөлтнүүд ч үйл үрээс зайлж чадаагүй” (*Францын даяан, 2009.02.17*) хэмээжээ.

*“The soft voice of the sacred
Friend is heard under holy ground,
The human flame shines for the divine voice:
It will cause the order of celibate monks to be ruined,
And to destroy the sacred (or false) temples of the impure ones.”*

*“Адислагдсан Андын найрсаг аялгуу газрын доорх зүрх болно,
Хүмүүний гал тэнгэрийн аялгуунд сүлэлдэнэ:
Санваартан хуврагуудын дампуурлыг зарлаж,
Бузарлагдсан нэгний буруу адислагдсан сүм хийдүүдийн хойтохыг унишина.”*

“Адислагдсан Андын найрсаг аялгуу газрын доорх зүрх болно,” гэсний “Адислагдсан Анд” нь Их Багшаас Авшиг хүртсэн шавь нар, “найрсаг аялгуу” гэдэг нь бурханы дуу хоолойтой нэгдэх аялгууны бясалгал, энэ бясалгалыг битүүмжилсэн байдалд хийдэг тул бясалгалын төвүүдийг газрын доорх зүрх гэж зөгнөх боломжтой юм. Их Багш бээр анхны бясалгалын төвүүдийг байгуулсны эхнийх нь болох Тайваний Миаоли дахь Шиху төвд 1988-1989 онд газар доорх бясалгалын 176 агуй байгуулсныг чухамхүү “газрын дорх зүрх” гэж онож зөгнөжээ. Ийнхүү бясалгаснаар энд “гал” гэж нэрлэсэн дотоодын гэрэл хийгээд тэнгэрийн аялгууны хүчээр “Хүмүүний гал тэнгэрийн аялгуунд сүлэлдэнэ.” гэсэнчилэн хүмүүн бээр гэгээрлийг олцгоохыг мадаггүй зөгнөжээ.

*“Санваартан хуврагуудын дампуурлыг зарлаж,
Бузарлагдсан нэгний буруу адислагдсан сүм хийдүүдийн хойтохыг унишина.”*

“Очир огтлогч” сударт Бурхан Багш бээр өөрийн үүсгэсэн шашныг “ирээдүйд... дээдийн ном машид тийн эвдэрнэ” гэж айлдсантай их цөвүүн цагт хамаг амьтныг гэтэлгэж туслах боломжоо алдаад байгаа шашны доройтлыг зөгнөсөн энэхүү зөгнөлийн санаа таарч байна. “Машид тийн эвдэрнэ” гэдэг нь үнэндээ шашны бууралт доройтол төдий зүйл бус Гэвш Майкл Роачийн “Очир огтлогч” (тал 221) номд тэмдэглэснээр “шашин эцсийн мөхөлдөө хүрнэ” гэсэн байна.

Бурхан Багш бээр айлдахдаа: “Сайн цагийн Будда залрах үед түүний гэгээрлийн сургаалийг дагаж Их хөлгөнийхэн төдийгүй бусад бүх амьтан гаслангаас ангижирна” хэмээжээ (*Богд Зонхов Бодь мөрийн зэрэг, 2006, тал 236*).

Хамаг амьтныг гэтэлгэхийн тухайтад гэгээрлээс өөр арга зам гэж үгүй бөгөөд Их Багш Чин Хайн олон шавь нарнь гэгээрлийн баталгаа болж тав дахь түвшинд хүрчээ. Тав дахь түвшин нь Бурхан Багш, Есүс Христийн заларч буй, Их Багш хэмээгдэгч бурхадын суудаг орон мөнийг Тэр бээр 2006 онд НҮБ-ын төв байранд тавьсан “Чанагуухи ертөнцийн нууц” айлдвартаа тайлбарласан байдаг. Бурханы зэрэгт хүрнэ гэдэг нь тоолшгүй олон амьтныг нэгээхэн ч бээр хоцроолгүй таалалдаа болгоон, бүхнийг мэдэгч төгс төгөлдөр билэг билгүүнийг эрхшээсэн хүний хөгжлийн өндөр түвшин юм. Үүнээс ч олон шавь нь бодьсадын түвшинд хүрчээ. Ийнхүү Чин Хай Багшийн ачаар хүмүүн бээр харанхуй мухар сүсгээс мултарч, өөрийгээ олсон ухамсрын хөгжлийн бодит түвшинд хүрч байгаа болно. Бурханы ивээлд багтсанаараа бид аврагдах юм. Аврагдах гэдэг нь та биднийг муу үйлийн үрийг үүрч эдлэх зовлонгоос ангижруулж, сүнсийг маань аварна гэсэн үг юм.

Их Багш бээр 2003 оны сүүлч гэхэд хүн төрөлхтний 99, 8 хувийнх нь сүнсийг нэгдүгээр ертөнцийн дээр хүргэж (сүнсийг нь сэрээж) аврал хайрласнаар хүн төрөлхтний Алтан

үеийг эхлүүлсэн билээ. Бурханы ивээлд багтсанаараа бид гэтэлгэгдэх юм. Их Багш Чин Хай: “Арьяабалын бясалгал нь биднийг 3 ертөнцийг давуулах цорын ганц арга юм” гэж Шинэ Зеландид 2002 онд ном тавихдаа айлджээ. Гэтэлгэгдэх гэдэг нь таны хэдэн зуу, мянган төрөлдөө олж авч чадалгүй цөхөрч явсан тэр зүйл мөн бөгөөд хэрэв та эс хүсвэл ахин төрөл авахгүйгээр мөнхжингийн оронд, төгс амгалан ноёрхсон жаргалангийн ертөнцийн харьяат болно гэсэн үг юм.

Их Багш Чин Хайн айлдсанаар гэтэлгэгдэх буюу чөлөөлөгдөх гэдэг бол харамсалтай нь ертөнцийн бүх номыг уншуулаад ч бүтэх зүйл хараахан биш юм. Тиймдээ ч хүн төрөлхтөн аргаа олохгүйгээс болж дэлхийг даахааргүй болтол дээр нь шавцгааж, харин Диваажин, Бурханы орон эзгүйрсэн хэрэг. Бидний мэдэх их номч багш нар болох Бакула ринбүүчий, Гүрдаваа ринбүүчий, IX Богд нар Монголд төрөхөө амласан нь хэрэв тэд хамаг амьтны тусын тулд ийм сонголт хийгээгүй л бол сансрын хүрдийг гэтлэн давах нь амар хэрэг биш болохыг эндээс нэгэнтээ харж болно. Гэтэл бид хүсвэл Бурханы авралаар энэ бүхэн эдүгээ нэгэнт боломжтой болж байна. Авшиг авснаар таны урьд насны бүх нүгэл хилэнц ариусч, заяа төөргийг тань дэлхийн ямар ч төлөгч хэлж чадахааргүй болох юм. Дэлхийн олон сая хүн Их Багшаас Авшиг хүртэж Түүнд шавилж байна. Их Багш биечилэн оролцсон “Дэлхийн энх тайвны төлөө” олон улсын даяан бясалгалыг 10 оронд 31 удаа хийсэн ба зарим даяан бясалгал нь 20000-30000 бясалгалчийг хамарчээ.

Их Багшийн Арьяабалын бясалгалын төв одоо дэлхийд 77 орны 202 хотод ажиллаж байна.

*“The great amount of silver of Diana and Mercury,
The images will be seen in the lake:
The sculptor looking for new clay,
She and Her followers will be soaked in gold.”*

*“Диана хийгээд Меркурийн их мөнгөн эрдэнэс,
Төрхөө нуурнаа тольдоно:
Урлал шинэ ертөнц рүү тэмүүлнэ,
Бүсгүй шавь нартайгаа алтанд умбана.”*

Диана бол эртний Грекийн домгийн сарыг эрхшээгч бурхан, Меркури бол огторгуй хийгээд илч гэрлийн Бурхан гэвэл Их Багшийн уран бүтээлийг эдгээр бурхадын их мөнгөн эрдэнэсээр төсөөлөн үзэж болох юм.

“Диана хийгээд Меркурийн их мөнгөн эрдэнэс,” нь Их Багшийн уран зураг, яруу найраг, дууны ая, хувцас болон гоёл чимэглэлийн үнэт эдлэлийн загвар, зохион бүтээлт зэрэг бүх хэлбэрийн уран бүтээл нь дээд ертөнцийнх лугаа өнгө, өгүүлэмж зохирсныг, тэдгээр бурхадын их баялагийг дэлхийд буулгасийм шиг асар цар хүрээг илтгэнэ. Их Багш бээр уран зураач, яруу найрагч, ая зохиогч, хувцас болон гоёл чимэглэлийн болон үнэт эдлэлийн загвар зохион бүтээгч бөгөөд уран зургийн үзэсгэлэн нь АНУ, Япон, европын хэд хэдэн оронд, мөн зохион бүтээсэн хувцасны загварыг нь 1995 онд дэлхийн загварын ертөнц гэгдэх Лондон, Парис, Милан, Нью Йоркт үзүүлжээ. Их Багшийн загвараар үйлдсэн үнэт эдлэлүүд Швейцарийн Байзел хотноо болсон Дэлхийн шилдэг загварын үзэсгэлэн, Парисын олон улсын үнэт эдлэлийн үзэсгэлэнд тус тус тавигджээ.

Их Багшийн яруу найргийн “Эрвээхэйн мөрөөдөл”, “Хуучин цаг”, “Мартагдсан дурсамж”, “Өмнөх амьдралын зам мөр” зэрэг 9 номын “Аниргүй нулимс”, “Эрин зууны хайр” ном нь дэлхийн 38 хэлээр орчуулагджээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн лекц, хөгжим, концертийн аудио, видео хуурцгууд, MP3, CD, DVD-нүүд нь дэлхийн 39 хэл дээр хэвлэгдсэн ба өөрөө үг, аяыг нь зохиож дуулсан болон найруулж аялгуулсан дууны “Хайрын домог туульсад хүрэх зам”, ”Хаа эргийн хайр”, “Цагийн

сүүдэр”, “Шөнийн зүүд”, “Үүрд хадгалаарай”, “Энэ өдөр, тэр өдөр”, “Өмнөх амьдралын зам мөр”, “Эрдэнэсээр чимсэн шүлгүүд”, “Алтан лянхуа” зэрэг 19 CD ба DVD нь олны хүртээл болоод байгаа билээ. “Чулуун Буддатай хөөрөлдсөн нь”, “Нэрлэшгүй”, “Шөнийн зүүд”, “Голын эрэг дээр”, “Чамайг би үүрд хайрлана” олон шилдэг дууг зохиогч өөрөө болон Америк, Гонконг, бусад орны нэрт дуучид дуулжээ.

Алтан эриний 8 дахь жил буюу 2011 оны 4-р сарын 10-нд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн “Эрин зууны хайр” шүлгийн номын нээлт АНУ-ын Калифорни мужийн Лос Анжелес хотын Серитоссын Урлагийн төвд болж, улмаар Их Багшийн зохиолын дууны “Эрин зууны хайр – Мөнхийн хайр” концертийг Грэмийн шагналт хөгжмийн зохиолч Билл Кинлайффе найруулан тоглуулжээ.

Дэлхийн оюун санааны удирдагч, яруу найрагч, зураач, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн “Аниргүйхэн нулимсыг хайрлахуй” шүлгийн номоор бүтээсэн мюзиклийн тоглолт Алтан эриний 9 дэх жил буюу 2012 оны 10-р сарын 27-нд АНУ-ын Калифорни мужийн Лос Анжелес хот дахь жил бүрийн Оскарын шагнал гардуулдаг, Хойд Америкт хамгийн томд ордог Шриний танхимд болсон ба мюзиклийг Грэмийн болон Оскарын 5 удаагийн шагналт Хорхе Календрелли, 2 удаагийн шагналт Аль Оскар Каша, Генри Кригер, Грэмийн шагналт Эмми Дуг Кацарос, Оскарын 2 удаагийн шагналт Грэмми Дэвид Шир нар найруулан тавьсан ба уг мюзиклийн гол дүрүүдэд Грэмийн 2 удаагийн шагналт Джон Секада, Грэмийн шагналт Джоди Ватлей, Блэк Ухури, Тонигийн шагналт Магуайр Майкл, Дебби Гревайтте, Кирилл Кулиш нарын олон нэрт жүжигчид болон дэлхийн 16 орны дуу хөгжим, соёлын төлөөлөл оролцсон юм.

Их Багшийн “Тэнгэрийн урлаг” уран зургийн цомог, дэлхийн шилдэг борлуулалттай номын тоонд багтдаг “Ноход миний амьдралд”, “Шувууд миний амьдралд”, “Эрхэм ариун амьтад” хэмээх уран сайхан, фото зургийн ном, “SM Тэнгэрийн хувцас” ном нь хүн төрөлхтний оюуны санг чинагуух сэтгэлгээээр баяжуулж байгаа билээ.

Дашрамд тэмдэглэхэд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн “Шувууд миний амьдралд” номын монгол хэвлэлийн нээлт 2009 онд, “Эрин зууны хайр”, “Аниргүйхэн нулимс” яруу найргийн номыг монгол хэлнээ хөрвүүлж, нээлтийг 2011, 2014 онд Улаанбаатар хотноо тус тус хийсэн болно. Их Багшийн адисыг хүртээж буй уран зураг, дуу, шүлгийн эдгээр бүтээлүүд нь Багшийн чин энэрэл хайрыг зүрх сэтгэлд цогцлоож, эх болсон зургаан зүйл, хамаг амьтанд туслуулахаар бидний дотоодын хайрын урсгалыг нээж өгдөг.

Номын сангийн олон улсын холбооны гишүүн агсан Тайваний Карл Мин Ку хэлэхдээ: “Их Багш Чин Хайн уран бүтээлд хайрын адислал хийгээд эгэлгүй орчлонгийн чанарууд шингэж, гоо үзэсгэлэн хийгээд мөнх оршихуйн ертөнц цогцолдог юм” гэсэн нь зөгнөлийг тодотгож байна.

“Төрхөө нуурнаа тольддоно:” гэсэн нь Их Багшийн Тайваний Шихуд байгуулсан бясалгалын төвийн дэргэдэх Баруун нуур байж болох бөгөөд Багшийн уран бүтээлийн гол газрын нэг, загвар бүтээлийг нь түрүүлж харж тольддог газар юм.

Их Багшийн уран бүтээл нь ямагт дэлхийгээс хальсан өөр хэмжээст хамааралтай байдаг ба басхүү тэрхүү ертөнцүүдийг сайн мэдэх хүний хувиар урын сан нь чинагуух сэтгэлгээгээр баяжсан байдгийг *“Урлал ийнэ ертөнц рүү тэмүүлнэ,”* гэжээ. Их Багшийн уран зураг, гоёл чимэглэлийн бүтээлийн нэр хүртэл уг зөгнөлийг батална. “Диваажингийн цэцэг”, “Зохирол”, “Тэгээрэл”, “Хамтдаа дэвшье”, “Эрх чөлөө”, “Нямба”, “Шинэ эрин”, “Диваажингийн бороо”,

“Чөлөөлөлт”, “Ирээдүйн Будда”, “Билгийн нүд”, “Сүнсээр тольдохуй”, “Сүнсний хавар”, “Гэгээн хун”, “Гэрэл, аялгуунд бясалгахуй”, “Бяцхан сахиусан тэнгэр” гм.

Ертөнцийн хайр бол хүлээслэгдсэн хайр, удаах хайр бол сүнсний эрх чөлөө, гуравдахь нь та өөрөө хайр болж хувирсан хаа сайгүй орших хайр гэвэл нь Их Багшийн бүх хэлбэрийн уран бүтээлүүд нь хоёр ба гурав дахид харъяалагдана.

“Бүсгүй шавь нартайгаа алтанд умбана”.

Их Багшийн гоёл чимэглэлийн алт, мөнгөн үнэт эдлэлүүд нь Түүний сая сая шавь нарын төдийгүй дэлхийн хүмүүсийн байнгын хэрэглээ болсныг нүдээр үзсийм шиг зөгнөжээ. Шинэ эриний оюун санааны залуурч Их Багш Чин Хай, Түүний хүн зон, дэлхийг адислан гийгүүлэхийг зөгнөсөн олон бадаг зөгнөл ийн цааш үргэлжилжээ.

Бурханыг таниасай билээ гэх чин эрмэлзэл минь хүмүүнд хүрээсэй хэмээн залбирч зөгнөлийг үүгээр жаргаасу.

Хамаг амьтан цаглашгүй олон төрөлдөө сансрын хүрдэнд эргэлдэж, 6 төрлийг дамжин төрж, өвдөж, үхэж зовж шаналсан энэ гамшгаас хагацан чөлөөлөгдөж, гурван ертөнцийг туулан гэтлэх 3 боломжийг Их Багш Чин Хай номлосон байна (*Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ, 6 дахь хэвлэл, 2007, тал 91*).

1. Итгэн дагах. Их Багш болон Гэгээнтнүүдийн аль нэгэнд итгэн сүсэглэж, хорвоог орхих үед тань гэтэлгэж өгөхийг гуйх.
2. Их Багшаас авшиг хүртэх. Энэ нь зөвхөн өөрийгээ төдийгүй хамаг амьтан хийгээд гэр бүл, үр удмаа хэдэн үеэ нь аварч чадах хамгийн эрхэм зам.
3. Авшиг хүртсэн хүний садан юмуу найз байх. Энэ тохиолдолд та нас нөгчөөд бүр тамд уначихсан байлаа гэж бодоход ач гуч тань Их Багшаас авшиг хүртэх юм бол та нэн даруй чөлөөлөгдөн тэнгэрийн оронд очих болно. Бас хэрвээ бид авшиг хүртсэн хүний найз нөхөр нь бол Багшийн тусыг хүртэнэ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай шавь нартаа “Та нар дампуурдаггүй компаний даатгуулагч нар” гэж орчин цагийн үг хэлээр хүн бүрд ойлгогдохуйц айлдсан нь Их Багш бээр шавь нарынхаа, бас өөрт нь итгэдэг хүн бүхний хувь заяаг хариуцахаар батлан дааж буй хэрэг юм.

Та бурхангүйн үзэлтэн байж мэднэ. Гэвч энэ нь таныг уучлах шалтаг болохгүй биз ээ. Бидний ойлгодоггүй олон юмны л нэг нь. Шинжлэх ухааны мэдлэг гээчээр түрүү барьж зөрүүдэлснээрээ бидэнд хожсон юм нэгээхэн ч үгүй, харин алдсаныг нь тооцож баршгүй. Бид өөрсдийгээ таних аргагүй болсон нь хамгийн том алдсан юм маань. Шинжлэх ухаан харамсалтай нь энэ хохирлыг төлж өгч чадахгүй. Та бидний өөрийгээ гэж бодож байгаа маань бид хараахан биш аж. Та бид махбодь, хувцсаа л харж байна. Таны харъяалал бол ухамсар тань. Бидний ойлгохгүй юм их бий. Үүний нэг нь Гэгээрэл, Бурхан.

Их Багшийн: “Гэгээнтэн бүхэнд өнгөрсөн бий, гэмтэн бүхэнд ирээдүй бий” хэмээсэн айлдварт хүмүүний боломж хийгээд чадамж бүхэлдээ цогцолно.

Бурхангүйн үзэл нь өөрөө бурангуй үзэл, хүмүүний харанхуй мунхагийн хэмжүүр, үр дүн нь оюуны хоосрол юм байна. Амьтдаа өөрийн бурханлиг чанарыг таньж гэмээ нь юутай гайхамшигтай вэ. Үүний учир хүн бүрийн төлөө залбирсу.

Нострадамусын дээрх зөгнөлийн тухайтад орчуулгын утгыг онож барин, агуулгад авцуулан тайлваас аштайсан гэх хирээсээ хэтийдсэн хүсэл үүдсэндээ өчүүхэн хүн санаа зовниж сууна.

Уншигч та бээр алдаа мэдгийг ууч сэтгэлдээ цайруулж хүлцэн болгоох аваас юутай баярлахсан билээ.

Техникийн шинжлэх ухааны доктор (D.Sc), профессор, яруу найрагч Гүррагчаагийн Лхагваа

Тайлбар зүүлт

¹ Зөгнөлийн англи эхийг дараах эх үүсвэрээс авсан болно:

Nostradamus -The great prophecies, Supreme Master Ching Hai, European Lecture Tour 1999: www. God's Direct Contact -The Way to reach Peace, Taiwan, 106 дахь тал

² дээрх эх сурвалж, Mother of the Millennium, 107 дахь тал

³ дээрх эх сурвалж, Nostradamus - The great prophecies, 99 дэх тал

⁴ Хоосон чанар бол буддизмын гүн ухааны суу билгийн оргил болсон номлол юм. Бурхан Багш бээр: “Бүх юмс уг мөн чанараараа хоосон бөгөөд бидний сэтгэлийн нэрийг тэддийхэн, тэдгээр бүх юмс шүтэн барилдсаны учир хоосон чанартай, шүтэн барилдахуй хийгээд хоосон чанар нь нэгэн сургаалийн салшгүй хоёр тал” (*Зона Ринбүүчий ламтны айлдвар “Амьдралаа дээдийн номд урвуулахуй”, 2006, Ч.Хатанбаатарын орчуулга, тал 13*) гэсэн бол Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай: “Үнэндээ бол ертөнцөд оршин байдаг зүйл гэж нэгээхэн ч үгүй. Энергийн бөөгнөрөл болон хайрын орон зай л гэж байдаг, тэр нь заримдаа янз бүрийн хэсэгт хуваагддаг. Энэ нь цахилгаан гүйдэл нь чийдэн, дамжуулагч утас, микрофон гэх мэт өөр өөр зүйлд оршдогтой адил юм” (*Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ, 6 дахь хэвлэл, 2007, тал 53*).

Бурхан Багшийн “Хамаг юм өөрийн уг мөн чанараар эс бүтсэн бөгөөд хоосон чанартай” хэмээх номлолыг дараах байдлаар ойлгох юм (*Бурхан Багшийн сургаал, Н.Энхбаярын орчуулга, 1996, тал 56-69*). Үүнд:

□ Энэ ертөнцөд бүх юм цаг нь болж нөхцөл бүрэлдэхэд буй болж, мөн цаг нь болж нөхцөл бүрэлдэхэд байхгүй болох тул юмст өөрийн мөн чанар гэж үгүй, бүгд хоосон чанартай. Ийм учраас ертөнцийн бүх юм хоорондоо шүтэн барилдсан, нэгдмэл юм.

□ Энэ ертөнцөд бүх юм цаг нь болж нөхцөл бүрэлдэхэд буй болж бүтэх тул өөрийн гэх мөн чанаргүй, хоосон чанартай, тиймээс бүх юмсын хооронд өчүүхэн ч ялгаа байхгүй, ертөнцийн бүх юм хоорондоо ижил тэнцүү (Юмсыг сайн муу, сайхан муухай, буруу зөв, бузар ариун, мөнх мөнх бус гэх нь зөвхөн тэдгээрийг харж буй хүмүүний сэтгэлийн үүтгэл төдий).

Ийнхүү хамаг юм хоосон чанартай, хоорондоо шүтэн барилдсан, нэгдмэл юм.

□ Ертөнцийн юмс мөн чанаргүй учир бие даан оршиж эс чадна, хоорондоо холбоотой, нэг нь нөгөөгөөсөө шалтгаалан оршдог. Ийнхүү хамаг юм хоосон чанартай, хоорондоо шүтэн барилдсан, нэгдмэл юм.

□ Энэ ертөнцөд бүх юм цаг нь болж нөхцөл бүрэлдэхэд буй болсон, өөрийн мөн чанаргүй, хоосон чанартай тул тэдгээрийг оршин буй хэмээн нотолж болохгүй. Тэдгээр нь цаг нь болж нөхцөл бүрэлдэхэд буй болж үнэхээр оршин буй тул бас огт байхгүй гэж хэлж болохгүй. Энэ ертөнцийг цаг зуурын юмуу эсвэл бодит чанартай гэж болохгүй (*мөн тэнд, тал 59, 61*).

□ Харин цаг хугацаа, нөхцөл шалтгааны хооронд бүх юм хувирч өөрчлөгдөн байснаараа эс байна. Үүнийг ямарч хүч өөрчилж эс чадна. Энэ бол ертөнцийн цорын ганц хувиршгүй үнэн.

Хоосон чанарын тухайд юуны өмнө энэ хүлээст амьдралын дунд хураасан бол барагдаж, бүтээсэн бол эвдэрч, учирсан бол хагацаж, төрсөн бол үхэж төгсдөг энгийн үнэнийг ухаардаггүй мунхаг сэтгэл, мөн үйл үрийн хуулийг ухаараагүй мунхаглал хоёроос бүх зовлон үүдэлтэйг ойлгох юм. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бээр эх дэлхий устах эсэх талаарх асуултанд: “Үүссэн бүхэн цагаа болохоор устах нь дамжиггүй” (*Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ, 6 дахь хэвлэл, 2007, тал 21-23*) гэж хариулжээ.

Тэгэхээр дэлхий хүртэл устах нь Хоосон чанарын онол ёсоор болох хэрэг. Харин хугацааны хувьд эртэдсэн байж болох бол энэ нь хүмүүн бидний үйлийн үрийн шалтгаантай холбоотой асуудал. Үүний өмнө дэлхийд дөрвөн ч удаа галав юүлж, Лимур, Атлантын агуу соёл

иргэншлүүд устаж, Грек-Ромын гайхамшигт соёл улмөргүй арилж, Чингисийн их гүрний сураг тасарснаас эхлээд биднийг зөвхөн хоосон чанарын жишээ л тойрон хүрээлж байдаг. “Хамаг юм өөрийн уг мөн чанараар эс бүтсэн бөгөөд хоосон чанартай” хэмээх номлолыг бясалгаж (бодож эргэцүүлж) Үнэнийг ухаарваас “Би” хэмээн дөвийх үзлээсээ ангижирч, шунал хүслээсээ чөлөөлөгдөж, амьдрал хийгээд амьд явахын учрыг таньж, хүний төрхийг олж, сэтгэлийн амар амгалан лугаа учрах нь байна. Бясалгах нь тухайн агуулгад уусан нэгдэхийн нэр. Өөрөө тэрхүү үнэн болж хувирахын нэр. Хоосон чанарыг бясалгалаа гэхэд Оршихуй нь хоосон чанар болно гэсэн үг (*Ухаарал Бясалгал Гэгээрэл П.Бадралын орчуулга, 2010, тал 156*).

“Хоосон чанарын номыг анхааран сонсох нь 10 галвын турш өглөг, шагшаавад (ёс зүй), хүлцэнгүй, хичээнгүй, самади барамидыг дадуулан бүтээснээс ч илүү их буяны чуулганыг хураана. Гэтэл 10 галвын турш хоосон чанарын номыг бусдад номлосон буян үүнээс ч их, харин энэ нь хоосон чанарыг 1 секунд бясалгасан лугаа харьцуулахад өчүүхэн бага” гэжээ (*Зона Ринбүүчий ламтны айлдвар “Амьдралаа дээдийн номд урвуулахуй”, 2006, тал 276*).

Хоосон чанарыг бясалгаснаараа нэгдүгээрт: хүмүүн бээр өөрөөсөө эхлээд бүх юм өөрийн мөн чанараараа бүтээгүй, иймээс бүх юмсын хооронд өчүүхэн төдий ялгаа үгүй, ийнхүү ертөнцийн бүх юм хоосон чанартайг ухаарах юм. Хоосон сэтгэлийг дагасан сэтгэлийн амьтан болчихоод хоосон бүхний араас хөөцөлдөн хүсэл шуналын ёроолд живсэн хүмүүн бээр энэ үнэнийг ойлгох хүртлээ амьдрал хэмээн нэрийдсэн хоосон зэрэглэн дунд төөрч будилсаар байх юм. Хоосон чанартай сэтгэлд хөтлөгдсөн бүхэн зөвхөн хоосон дунд дуусна гэсэн үг. Мил Богд бээр айлдахдаа: “Ахуй орчлонгоос сэтгэл ангижирч, үл хураах, үл хийх, үл учрах, үл төрөхүйн хоосон чанарыг бясалгах нь гүрэм заслын дээд хэлбэр мөн” гэжээ (*Мял Богдын гэгээрсэн түүх, 2007, П.Бадралын орчуулга, тал 253*).

Шанзун Ервава: “Өглөө мөнх бусыг санаагүй бол өдрийн хугаст энэ ертөнцийн харьяат, өдрийн хугаст санаагүй бол үдэш оройдоо ч түүний харьяат. Энэ ертөнцийн харьяат байгаа цагт юу ч хийсэн гэгээрлийн үйл болохгүй” (*Амьдралын хүлээнээс ангижрахуй, 2007, П.Бадралын орчуулга, тал 100*).

Урьд нэгэн эр хоосорч ядуурсан баян хүнтэй таараад учрыг асуувал “хоосон Мяларайвыг дууриачихсан чинь хоосорчихлоо” гэж гомдоллосон гэдэг. Учрыг нь ололгүй дуурайчхаж л дээ. Манай нэг бясалгагч “Авшиг гэдгийг авчихсан чинь ажил ч үгүй, алдар нэр ч үгүй, орох орон ч үгүй болчихлоо. Сайхан байнаа” гэсийм. Энэ хоосрол бол ухаарал.

Энэ хорвоогийн бүх юмс зөвхөн нөхцөл бүрэлдэхийн үр дагавар бөгөөд нөхцөл бүрэлдэж буй болсон бүхэн мөнх бус.

Мөнх бустай хөөцөлдөх нь бүтэлгүйтэл, хүний амьдралын буруу зам юм бол мөнх юм бидэнд байдаг билүү? Бий. Дээр дурдсан эгэл амьдралын 8 санаа, дээр нь уур хилэн, атаа жөтөө, дайсагнал үзэн ядалт, өмчирхөл, өрсөлдөөн, ерөөс буддизмд үздэгээр 84000 нисваанис (муу сэтгэл) буюу ертөнцийн хор бүхнээр бохирдож бузартсан сэтгэлийг юуны өмнө хүсэл шуналын хүлээсээс чөлөөлж, түүн дээр битүү дарсан тоосыг арчиж ариусгаад харвал цаана нь халхлагдан буй нэг зүйл, тухайлбал харанхуй мунхаг сэтгэлд хүлэгдэж бие хэмээх гянданд хоригдсон жинхэнэ өөрийгээ олж авах юм. Энэ нь оюун санаа, ухамсар буюу сүнс юм. Бидний дотоод бурхан буюу бурхан чанар маань юм. Бидний уг мөн чанар маань юм. Энэ бол үүсэл, устал аль нь ч үгүй, үхэхгүй төрөхгүй, өвдөхгүй, өтлөхгүй, үүрд мөнх оршдог чанар юм. Угтаа энэ бол та өөрөө юм. Ертөнцөд хүн, амьтны төрлийг олсон ч, бирд буюу өлсгөлөн сүнс болж төрөөд зовж зүдэрсэн ч, тамд унасан ч, бузартсан бие махбодь, хорвоогийн шунал тачаалын хир буртаг дүүрсэн ёроолд унасан ч гэрэл гэгээ цацраасан хэвээр мөнх орших тэрхүү чанар юм (*Бурхан Багшийн сургаал, тал 78*). Засаж залруулах юм гэж огт үгүй төгс төгөлдөр чанар юм. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсанчилан энэ бол бидний далай лугаа чанар юм. Далайн шуурга усан онгоц живүүлж, хүмүүс яаж амиа алдсан ч энэ нь далайн гадаргууд болж буй төдий үйл явц юм. Далайг өчүүхэн ч сандааж эс чадна. Ошо Богдын хэлсэнчилэн энэ бол бидний огторгуй чанар юм. Үүл зангирч, цахилгаан нижигнэж, аадар шаагивч огторгуйд падлийгүй, тэрээр ийм юм болж буйг мэдрэхгүй. Энэ лугаа хүмүүн бид далайн шуурга, үүл, аадартай хөөцөлдсөөр дуусдаг. Харин жинхэнэ далай, огторгуй маань огтхон ч үл өөрчлөгдөнө. Ошо Богд бичиж байна: “Хэдийнээ бурхан атлаа бурхан болох гэж ядаад л. Хэдийнээ хаан атлаа хаан болох гэж шаналаад л. Ямархан инээдтэй. Унасан морио эрж яваа хүн яаж олох вэ” (*П.Бадралын орчуулга Чанадын чанадад, 2008, тал 122*).

Хүн бүр Бурханы мөн чанартай (*Бурхан Багшийн сургаал, тал 81*). Тиймээс бүх юм нэгдмэл юм. Хүмүүн бид сэтгэлд хөтлөгдсөөр уг мөн чанараа мартжээ. Гэгээрэх нь энэхүү үнэнийг ухаан ойлгож, сэтгэл санааны хүсэл шуналаас ангижирна гэсэн үг (*Бурхан Багшийн сургаал, Н.Энхбаярын орчуулга, 1996, тал 59*).

Их Багш Чин Хай: “Сүнс хэзээ ч төрөл арилждаггүй. Сэтгэлгээний зуршил, хүсэл шунал, сэтгэлийн хүлээс маань л төрөл арилждаг. Хэрвээ хүмүүн бид сүнсээ таньж мэдэн гэгээрч, бид болоод хамаг ертөнц хоорондын шүтэн барилдлагыг мэдчих юм бол хаана ч дахин төрөл авахгүй. Бид хэзээ ч төрөхгүй, хэзээ ч үхэхгүй” (*Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ, 6 дахь хэвлэл, 2007, тал 53*), “Тэгээрснийхээ дараа би ертөнцийн хамаг амьтан бие биетэйгээ шүтэн барилдсаныг олж харсан билээ. Бидний мөн чанар нэгэн ижил, бид бүгдээрээ нэгдмэл юм” (*мөн тэнд, тал 154*) хэмээн айлджээ.

Бясалгалын нь талаарх асуултад Мил Богд: “Энэ бол хөлгөн бүхний дээд, эгэл амьдралын 8 санааг салхинд хийсгэгч хэмээх шашны ёсон” гэж хариулжээ (*Мял Богдын гэгээрсэн түүх, 2007, П.Бадралын орчуулга, тал 168*). Эгэл амьдралын 8 санаа гээч нь зугаа цэнгэлд баясах, зугаа цэнгэл үгүйд уйдаг, алдар нэрд дурлах, алдар цол үгүйд гутрах, магтаал сайшаалд хөөрөх, муушаал зэмлэлд буурах, олз ашигт эрэмших, олз омоггүйд бухимдах зэрэг болно. Мил Богдын агүйд нь ирж хоол нэхээд юу ч олоогүйдээ уурссан ганзага хоосон анчид түүнд “Адгийн боол ч чамаас арай дээрийг идэж гайгүйг өмсдөг” гэж тавлахад нь тэрээр “Би хорвоод ховорхон аз заяатай хүн. Гадна талын хоол хүнс, хувцас хунар, нэр төрийг гаргуунд нь гаргаж, дотор сэтгэлийнхээ л хортон дайсныг амьд ахуйдаа ялан дийлэх тул энэ Замба тивд над шиг эр зоригтон, эрүүл ухаантан олдох болов уу даа” (*мөн тэнд, тал 182*) гэж хариулжээ.

Хоосон чанарыг ойлгосноороо амьдралынхаа утга учир гэж эрхэмлэж явсан бүхнийг салхинд хийсгэж, сэтгэлийнхээ хортон дайсныг амьд ахуйдаа ялан дийлж, өөрсдийгээ хамаг амьтны тусын тулд өргөл болгон байж дотоод мөн чанараа нээх нь үнэхээр эр зориг, эрүүл ухаан ажээ.

Хоёрдугаарт: хоосон чанарыг бясалгаснаараа хоосон чанарыг онох юм. Хоосон чанарыг оносноор бид юуг ойлгох вэ? “Хамаг юмс хоосон чанартай. Үүсэх ч үгүй, устах ч үгүй, хиртэх ч үгүй, цэвэрших ч үгүй, дундрах ч үгүй, дүүрэх ч үгүй болой... Зовлон үгүй. Зовлонгийн шалтгаан үгүй. Зовлонг хорьсон нь үгүй. Хорих зам ч үгүй. Бэлгэ билиг ч хоосон болохоор олдох хийгээд алдах юм нэгээхэн ч үгүй. Бодьсадва нарт олдох юм үгүй тул энэхүү билгийн хүчээр элдэв төөрөгдлөөс салж, гаслангуйн нойрноос сэрэх бөлгөө. Энэ бол оршихуйн гүн рүү орсон билгийн хараа. Түүнд би гэх зүйл үл олдоно. Би байхгүй бол хэн төрж, өтөлж, өвдөж, үхэх билээ. Тэгэхээр зовлон гэж үнэндээ байхгүй. Зовлон байхгүй юм чинь түүний шалтгаан ч, түүнийг хорьсон нь ч, хорих зам нь ч байхгүй. Энэ үнэнийг илэрхийлж нээж чадвал зүүд нойрноосоо сэрэх болно. Оршихуйн үнэн бол хоосон чанараас өөр юу ч биш” (*Ухаарал, Бясалгал, Гэгээрэл Агнистын гэгээ №7, 2010, тал 380-381, 383*). Хоосон чанарыг онох нь хүмүүний хөгжлийн дээд шатанд хамаарна. Юмс үзэгдэл хоёр талтай. Хүмүүний тухайтад нэг нь Хоосон чанар, нөгөө нь Шүтэн барилдлага. Бүх юм, үүний дотор хүмүүний бие, хэл, сэтгэлийн үйл нь гагцхүү буян ба нүгэлд хураагдана. Энэ бол Шүтэн барилдлага буюу Үйл үрийн хууль. Эергүү ба Сөргүү энергийн хууль ч гэж болно. Бидний бие, хэл, сэтгэлийн үйл нь буян ба нүглийн аль нэгтэй шүтэн барилдах юм байна. Та сайн үйл, сайн үг яриа, сайн санаа бодлоор буяныг бүтээнэ, эсрэгээр бол нүглийг хураана гэсэн үг. Тэгэхээр дээрх 3 үйлийг эергүү болгосноор хүн хэмээх системийн энерги нь хэлбэрийн хувьд эергүү болох нь ээ (*Термодинамикийн 2-р хууль ёсоор системийн энерги хэмжээний хувьд тогтмол байдаг. Тэгэхээр сэтгэл бүхий биологийн систем болох хүмүүний тухайд энергийн хэлбэр зонхилох үүрэгтэй байна*). Ингээд биеийн үйлийг цэгцэлж (*идэвхийллээс захиролд хувирах гм*), хэлний үйлийг зохистой болгож (*үг яриаг зохистой болгох, цөөлөхөөс эхлээд дуу хурааах гм*, үйлдвээс цаана нь сэтгэлийн үйл үлдэнэ. Сэтгэлийг номхотгож дадуулахаас эхлээд бүр сэтгэл үгүйн түвшинд хүрэхэд сая аливаа юмны нөгөө тал болох хоосон чанарыг онох юм. Үйлийн үрийг давж аливаа юмны нөгөө тал болох хоосон чанартай нүүр тулна. Угтаа оюун санаа, ухамсар буюу сүнс тань үлдэхдээ өөрийн уг гарвал төрх чанараар илэрнэ гэсэн үг. Энэ бол та бүхий л оршихуйтай, бурхантай нэгдэж буй үйл явц юм. Та огторгуй мэт, далай мэт зах хязгааргүй өргөсөн тэлнэ гэсэн үг. Гайхамшиг ингэж бүтдэг байна. Та тэр чигээрээ хайр болж хувирах юм. Үүнийг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бээр: “Хэрвээ бид үйл үрийн хүрдийг эвдлэн зайлж чадваас үхэх нь үгүй, төрөх нь үгүй, амьдрал үгүй, үйлийн үр үгүй, гагцхүү азжаргал, амар амгалан л ноёрхох оршихуйн тэр хэмжээст хүрнэ” (*Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ, 6 дахь хэвлэл, 2007, тал 60*) гэж айлджээ.

⁵ Бие, сэтгэл хоёр уусан сүлэлдэж нэгэн айзмаар лугшин долгиж байхыг самади хэмээн Шангидэва Богд тодорхойлжээ (*Ухаарал, Бясалгал, Гэгээрэл П.Бадралын орчуулга, 2010*).

Шри Чинмой Богд бээр 3 төрлийн самадийн талаар дэлгэрэнгүй бичсэнээс хоёрыг нь онцолвол (*Шри Чинмой Самади ба Сидхи, монгол орчуулга, 2010*): Савикалпа самадийн үед хүн түр зуур эгэл жирийн ухамсраасаа гарч ухаан алддаг. Энэ самадийн үед та 1-2 цаг тэс ондоо ертөнцөөр зорчино. Тэнд бараг юм бүхэн гүйцэлдэж биелсэн байх нь харагдана. Энэ дэлхийд таны хувьд гүйцэлдээгүй мөрөөдөл, дуусаагүй ажил сая саяараа бий. Харин савикалпа самадид орох үед та бараг юм бүхэн гүйцэлдэж биелсэн байна. Савикалпа самадийн үед янз бүрийн бодол санаа эргэлдэх боловч тэдгээр нь танд нөлөөлөхгүй. Таны бясалгал хэвийн, тайван явагдаж, дотоод ахуй тань эрч хүчтэй байна. Харин үүнээс бага зэрэг дээшилж нирвикалпа самадид хүрээд сүнстэйгээ нэгдэж чадвал тэнд бодол санаа огт үгүй болно. Орчлон ертөнцийн хөдөлгөөн тэнд төгсдөг. Тэнд байгаль, дэлхий гэж үгүй, зөвхөн цаглашгүй Амгалан, Жаргалан л бий. Мэдэгч хийгээд Мэдлэг хоёр нэгдэж нэг болно. Юм бүхэн намуун дөлгөөн болж, хамгийн тэнгэрлиг дээд онгодын дотор та цэнгэн баясна. Баяр баяслын шалтгаан хийгээд тэрхүү баяр баяслыг эдлэн цэнгэгч нь та болно. Түүгээр ч зогсохгүй та өөрөө тэрхүү баяр баясал нь болно (*тал 83-84*). Нирвикалпа самадид хүрээд бид нар ялгаа зөрөө гэгч тэр зүйлийн чанад гардаг. Тэнд оюун ухаан огт хэрэггүй болно. Нирвикалпа самадид ороод хамгийн түрүүн мэдрэх зүйл гэвэл зүрх маань хамаг орчлонгоос ч агуу уужим болохыг анзаардаг. Хорвоо дэлхий, орчлон ертөнцийг хязгаарлагдмал ухааны хүчээр харж төсөөлж байсан маань өөрчлөгдөж, бодит байдал дээр орчлон ертөнц гэдэг нь хязгааргүй уужим зүрхний маань дотор байгаа өчүүхэн цэгээс өөрцгүй болохыг харна. Нирвикалпа самадид цаглашгүй Жаргалан бий. Тэрхүү Жаргаланг хэмжиж, харьцуулж жишихийн аргагүй. Тэнд мэдрэх гуравдахь зүйл гэвэл Хүч, Шидийн хүчийг олсон бүх хүний хүчийг хамтатган нэгтгэлээ гэхэд тэр нь нирвикалпа самадид байх үедээ эзэмдэх Хүчтэй харьцуулахад юу ч болохгүй (*тал 88-89*). Өндөр дээд самадид хүрэх үед өрөөл бусдын бие даасан бодьгал чанар үзэгдэхээ больдог. Хүмүүс бидэнд хүн дүрээрээ бус далайд цутгах гол мөрөн адил ухамсрын урсгал байдлаар үзэгдэнэ. Гол горхи цутгаад далай болж хувирна. Самадид орохын тулд заавал гэгээрсэн байх шаардлагагүй (*тал 92-93*). Самади бол ухамсрын маш өндөр ертөнц (*тал 10*). Самадид хүрсэн хүн олон байдаг бол (*тал 91*) гэгээрэл нь Бурханы ухамсартай бүрэн төгс нэгдэхийн нэр (*тал 64*). Самадид орох нь бясалгалын цагаан толгойг мэдэхтэй адил (*тал 91*). Та самадид орох боловч самади таныг хувиргаж өөрчлөхгүй. Онгодыг олоод өндөр дээш хөөрнө. Яагаад гэвэл тэр үедээ та Бурхантай нэг байдаг. Гэвч биет ертөнцөд эргэж ирэхдээ жирийн л хүн болж хувирдаг. Харин ухамсраа хувиргах аваас хорвоогийн мунхагийн харанхуйд дахин хэзээ ч автахгүй (*тал 97*).

⁶ Их Багш Чин Хай бол арван нэгдүгээр түвшин (ертөнц)-ээс бууж ирсэн Оройн Дээд Их Бурханы шууд дүр, Дээд Аватар юм (*Аватарын талаар дор, энэхүү тайлбарын төгсгөлд үзнэ үү*). Хамаг дэлхий болон хүн төрөлхтний үйл хэрэгт эрч хүчтэй, шууд оролцож, мунхагийн харанхуйд живсэн хамаг амьтны сүнсийг сэрээж, билгийн мэлмийг нь агшин зуур нээж, сансрын хүлээснээс үе үеэр нь, сая саяар ньчөлөөлж, мянга мянгаар нь гэгээрэлд хүргэж, шавь нарынхаа өмнөөс урьд цаглашгүй төрлийнх нь үйлийн үрийг өөртөө авч байсан ийм аугаа үйл хүн төрөлхтний түүхэнд байсангүй. Их Багш бээр асар богино хугацаанд дэлхийн бараг бүх оронд айлчлан 325 удаа ном тайлжээ. 1999 онд зөвхөн 1 сарын дотор европын 18 оронд айлчилсан байх жишээтэй. Их Багш Чин Хай бээр 1983 онд Энэтхэг, Тайвань, Германд, 1984 онд Америкт Авшиг өгч эхэлснээс хойш бясалгал нь бүх шашин шүтлэгтэй хүмүүсийг хамарч, дэлхийн олон арван сая хүнийг оюун санааны хөгжилд удирдан залж байна. Их Багшаас Авшиг хүртсэн олон сая хүний цаана энэ олон үе, олон хүн, амьтныг хамарсан чөлөөлөлт явагдаж байна гэвэл энэ нь үгээр хэлж, тоогоор илэрхийлэх ч амаргүй үйл явц юм. Бурхан Багш бээр айлдахдаа: “*Сайн цагийн Будда залрах үед түүний гэгээрлийн сургаалийг дагаж Их хөлгөнийхэн төдийгүй бусад бүх амьтан гаслангаас ангижирна*” хэмээжээ (*Богд Зонхов, Бодь мөрийн зэрэг, 2006, тал 236*). Энэ үйл явц эдүгээ ёсоор болж байна.

Олон тэрбум Эрхэм ариун чанар бүхий (эрхэм ариун чанар хүн төрөлхтний дундаж 10%, дийлэнх нь 3 %), 40 сая Хайрын чанар, хэдэн тэрбум Диваажингийн чанарыг цогцлоосон аугаа

үйлстэн, Оройн Дээд Их Бурхан, Дээд Аватар эх дэлхийд, хүн төрөлхтний дунд залран буй нь юутай гахамшигтай.

Их Багшийн цогцлоосон Гэрэл, Аялгууны бясалгалын төв болон төлөөлөл нь Африкийн 12 орны 19 хотод, Америк тивийн 15 орны 75 хотод, үүнээс АНУ-д 42, Азийн 21 орны 49 хотод, Европын 27 орны 45 хотод, Номхон далайн 2 орны 14 хот, нийтдээ 77 орны 202 хотод ажиллаж, тэдгээрт янз бүрийн шашин шүтлэгтэй сая сая бясалгагч хамрагдаж байна.

Их Багшийн айлдвар, сургааль номлолын 20 ном, 325 DVD, түүний уран зураг, дизайны 3 ном, 200 гаруй шүлэг, яруу найраг, дууг багтаасан 26 ном, CD, DVD нь дэлхийн 38 хэлээр, “Агшин зуур билэг нээгдэх түлхүүр” оршил ном нь 74 хэлээр орчуулагдан хэвлэгджээ. Их Багшийн өөрийн хөрөнгөөр байгуулсан “Суприм Мастер” телевиз нь хүмүүнлэг энэрэнгүй нэвтрүүлгийг 4 тивийн үзэгчдэд 30 гаруй хэлээр 24 цагаар өдөр алгасалгүй нэвтрүүлэн хүн төрөлхтнийг соён гэгээрүүлэх ихажлыг 5 жил гаруйн хугацаанд цуцалтгүй гүйцэтгэсэн билээ. Энэ телевизийг зөвхөн хэл талаас нь аваад үзэхэд л НҮБ ажлаа 5-6 хэл дээр явуулдаг бол уг телевиз 30 гаруй хэлээр нэвтрүүлжээ.

Их Багш биечилэн оролцсон “Дэлхийн энх тайвны төлөө” олон улсын даяан бясалгалыг 10 оронд 31 удаа хийсэн ба зарим даяан бясалгал нь 20000 - 30000 бясалгалчийг хамарчээ.

Их Багш бээр уур амьсгалын өөрчлөлтийн тулгамдсан асуудал хийгээд заналхийлж байгаа аюулыг хүнтөрөлхтөнд 30 жилийн өмнөөс сануулж, 5 жил гаруйн өмнөөс дэлхийг аврах сүүлчийн хугацаа хийгээд арга замыгнь анхааруулан хэлж, зааж, эх дэлхийгээ аврах хөдөлгөөнийг өөрийн биеэр удирдан зохион байгуулж, улмаардэлхийн хэмжээний далайцтай ажлуудыг хийсний дотор 2010 оны эхний байдлаар 30 гаруй орны 166 хоолны газрыг хамарсан ногоон хоолны зоогийн газрын олон улсын сүлжээг бий болгож, энэ хугацаанд дэлхийн цагаанба ногоо хоолтны тоо хоёр дахин нэмэгдэж 1.5 тэрбумд хүрсэн ба уур амьсгалын тулгамдсан асуудлаарх олонулсын теле-бага хурлыг 12 оронд 27 удаа хийгээд байна.

Их Багш Чин Хай 1989-өөс 2010 оны 2 дугаар сарын байдлаар дэлхийн 1100 гамшгийн тохиолдолд хүмүүнлэгийн зориулалтаар хувиасаа 20 сая америк доллар хандивлажээ. Үүний заримаас дурдвал: 2001 оны 9-р сарын 11-нд АНУ-д өндөр барилгууд нурсан гамшиг, 2004 оны Энэтхэгийн далайн хар салхи, 2005 онд АНУ-д тохиосон Катерин хар салхи, мөн Кашмирийн газар хөдлөлт, 2008 оны БНХАУ-ын Сичуаний газар хөдлөлт, мөн оны Мянмар /Бирм/-ын Наргиаст болсон хуй салхи, азийн бусад оронд болсон байгалийн гамшиг, 2010 оны Гаитийн газар хөдлөлт, 2011 онд Японыг хамарсан далайн хар салхины аюул зэрэг гамшгийн олон тохиолдол болон дүрвэгсдийн асуудлыг шийдэхээс авахуулаад өнчин хүүхдүүдэд туслах ажлыг дэлхийн хэмжээнд хийж ирсэн билээ.

Их Багш бээр уран зураач, яруу найрагч, ая зохиогч, хувцас болон гоёл чимэглэлийн үнэт эдлэлийн загвар зохион бүтээгч бөгөөд уран зургийн үзэсгэлэн нь европын хэд хэдэн оронд, мөн зохион бүтээсэн хувцасны загварыг нь 1995 онд дэлхийн загварын ертөнц гэгдэх Лондон, Парис, Милан, Нью Йоркт үзүүлжээ. Их Багшийн загвараар үйлдсэн үнэт эдлэлүүд Швейцарийн Байзел хотноо болсон Дэлхийн шилдэг загварын үзэсгэлэн, Парисын олон улсын үнэтэдлэлийн үзэсгэлэнд тус тус тавигджээ. Ийнхүү Их Багшийн адислалыг хүн төрөлхтөн боломжит бүх хэлбэрээр нь хүртэж байгаа билээ.

Аватарын талаарх Шри Чинмой Богдын тайлбар

Йог бол төгс гэгээрсэн сүнс юм. Харин гэгээрсэн сүнснээс өндөр түвшинд хугас Аватар, түүнээс өндөр түвшинд Дээд Аватар байдаг. Аватар бол Бурханы шууд бууж ирсэн дүр юм. Йог бол цөөхөн хэдэн хүнтэй харьцах чадвартай. Аватар бол хамаг дэлхийн үйл хэрэгт оролцдог. Йог аниргүйхэн үйлдэнэ. Аватар эрч хүчтэй үйлдэж, итгэл төгс ярина. Зүйрлэн хэлбэл Йог бол бут сөөг, Аватар бол агуу том, асар өндөр мод юм (*Шри Чинмой Самади ба Сидхи, монгол орчуулга, 2010, тал 137*).

Аватар бол цаг ямагт Оройн дээд ертөнц хийгээд хамгийн доод ертөнцөд үйл хэргээ зэрэг явуулдаг. Аватар бол их далай. Йог бол гол мөрөн эсвэл цөөрөм. Хүн төрөлхтний ухамсрыг

дээшлүүлэх гэж оролдохдоо Йогууд заримдаа хорвоо дэлхийн мунхгийн харанхуйд автах нь бий. Харин Аватар бол хамгийн дээд, хамгийн доод хоёрын аль алинд нь зэрэг орших ба хамгийн доодод байлаа ч гэсэн түүний нөлөөнд автдаггүй. Хүн төрөлхтнийг хувирган өөрчлөх их үйлсэд Аватарын юу хийж гүйцэтгэж чадах нь Йогийнхтой харьцуулахад хязгааргүй билээ (*Мөн тэнд, тал 137*).

Энэтхэг философи болон сэтгэл зүрхний сургаалд өгүүлснээр бол Аватар гэдэг нь Дээдгэгээнтэй өөрийн дураар харилцах чадвартай Дээдгэгээний шууд бууж ирсэн дүр юм. Ихэнх Йогд ийм чадвар байдаггүй. Өндөр дээдхамсарт хүрч Бурхантай холбоо тогтоохын тулд Йог хүнд хоёр гурван цаг шаардагдана. Бурхантай нүд ирмэхийн зуур холбоо барих чадвар Йог хүнд үгүй. Зөвхөн Аватар л Бурхантай ийм холбоотой байдаг. Аватар бол жирийн хүний ёсоор хэлж ярьж, идэж ууж, амьсгалж амьдардаг. Гэвч өндөр дээд ухамсарт хүрсэн үед нь хэрэв та түүний тэр ухамсрыг зэрвэсхэн ч гэсэн харж чадвал хамаг амьдрал тань түүний өлмийд хүлцэнгүй боол мэт сөхрөх болно. Тэгээд хөөгдөж туугдаж, хөлд нь өшиглүүлсэн ч та түүнийг үнэнч нохой мэт дагаж явна. Яагаад гэвэл энэ дэлхийд ондоо хэний ч өгч үл чадах эгнэшгүй эрхэм эрдэнэсийг түүний дотроос та олсон юм. Аватарын агуу өндрийг бүдэг бадагхан, ирмэх агшны зуур ч атугай харж чадахын тулд аливаа хүн сэтгэл зүрхний асар өндөр ухамсрыг олсон байх шаардлагатай. Аватарын ухамсрыг хэрхэвч тайлбарлаж илэрхийлэх аргагүй. Аватар Гүрү (*Их Баги*)-тэй болно гэдэг хүний амьдралд тохиож болох хамгийн эрхэмээс ч эрхэм ерөөлт учрал билээ (*Мөн тэнд, тал 138*). Аватар дүрээр бууж ирсэн Бурхан бол Бурханаас Өөрөөс нь хавьгүй их нигүүлсэнгүй байдаг гэж агуу тэмүүлэлтэй хүн ухаарах болно. “Хэрэв би ямар нэг буруу хэрэг хийчихвэл Бурхан намайг шүүж, үйлийн үрийг минь эдлүүлэх болно. Гүрү бол тийм биш ээ. Эрхэм дотны шавь нараа Тэрээр зөвхөн энэрч хайрлаж л чаддаг юм зэрэг. Тийм ч учраас надад оногдсон шийтгэлийг Гүрү минь өөртөө хүлээдэг юм зэрэг” гэж тэрхүү эрэлчин (шавь) хэлнэ. Хэрэв эрэлчин хүн чин сэтгэлийнхээ угаас, асар их хүчээр Бурханд залбирч, Бурханыг дуудан уйлах аваас Бурхан бээр түүнд шийтгэл хүлээлгэлгүй өршөөл хүртээж болох юм. Харин Аватар Гүрүтэй шавийн хувьд түүний хүлээх учиртай шийтгэлийг нь Гүрү шавийнхаа өмнөөс хүлээх болно. Дэлхий дээр байгаа Аватар өмнө нь ирж байсан бүх Аватарын ухамсрыг илэрхийлж байдаг (*Мөн тэнд, тал 139*).

Аватарын хувьд юм бүхэн тэс одоо. Аватар бол Бурханы шууд бууж ирсэн дүр болохоор ямар ч байдлаараа төгс төгөлдөр байх ёстой. Яагаад гэвэл тэр Оройндээдийн төлөөлөгч билээ. Ондоо Багш нар ч бас Бурханы дүрүүд боловч эрдмийн зэрэгтэй их сургуулийн багш, цэцэрлэгийн багш хоёр нь хичнээн их зөрүүтэй байдаг шиг Аватар болон Гэгээрсэн Багш нар хичнээн их ялгаатайг ухаарах хэрэгтэй (*Шри Чинмой Багийн төгс мэргэн сургааль, монгол орчуулга, 2010, тал 20*).

⁷ Нарийн энергийн гэж нэрлэгдэх ухамсрын 9 ертөнц буюу түвшин бидний дээр оршиж буй бөгөөд 3 дахь ертөнцийг давж 4 дэх түвшинд хүрэхийг гэтэлгэгдэх, чөлөөлөгдөх гэнэ. Их Багш Чин Хай 2008 онд америкийн Байгаль орчны дуу хоолой радиогийн сурвалжлагчтай ярилцахдаа энэ нь 100 000 нартай тэнцэх гэрлийн ертөнц гэсэн бол 1992 онд НҮБ-ын төв байранд тавьсан “Чанагуухи ертөнцийн нууц” айлдвартаа “тэр нь ер бусын гайхамшигтай гэдгээр ч хязгаарлагдахгүй. Энэ ертөнцийн тухай энгийн хүмүүст эгэл жирийн үг хэлээр өгүүлэх нь тэрхүү ертөнцийн эзнийг гомдоох байх гэж зүрхшээж байна. Учир нь энэхүү ертөнц нь маш үзэсгэлэнтэй, харин гэрэл гэгээнд хүрэхийн өмнө зарим газраа түнэр харанхуй байдаг” (*Төгс Гэгээрсэн Их Баги* Чин Хай “Агшин зуур билэг нээгдэхийн түлхүүр”, *Үлгэр дэвтэр, тал 30*) гэж тайлбарласан байна.